ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

# ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2020 ОН

ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020.12.08

| № | Заалт | Хэрэгжилт |
|---|---|---|
| | | **Нэг: Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн** |
| 1. | Монгол улсын тогтвортой хөгжил үзэл баримтлал-2030"-д заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл | **Зорилт 1. Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана.**<br><br>Тус эрүүл мэндийн төвд Хан-Уул Дүүргийн хөрөнгө оруулалтаар Сүвэн-Уул ХХК-с 21 нэр төрлийн 26 ширхэг нийт 69,8 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдсэн. Мөн ЭМЯ-с Зөөврийн дижитал рентген аппарат 114сая төгрөг, Дижитал рентген аппарат 256,3 сая төгрөг, Зөөврийн ЭХО аппарат 18,9 сая төгрөг, амьсгалын аппарат 34,9 сая төгрөгөөр нийлүүлсэн. 2020 оны 11-р сарын 30-ны байдлаар Дээд шатны байгууллагаас 27 нэр төрлийн 39 ширхэг нийт 540,6 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна.<br><br>Даатгуулагчийг эрүүл мэндийн улмаас үүсч болох санхүүгийн эрсдлээс хамгаалах зорилгоор 18-аас дээш насны бүх даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношлогоонд хамруулахаар Багц шинжилгээний бүртгэлийн ажилтан шинээр аван багц шинжилгээнд илгээж байна. Грандмед, Гэгээн ар үр, Сөүл эмнэлгүүдэд даатгуулагч тухайн насны ангилалаараа үзлэг оношилгоонд эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтөөр хамрагдаж байна. 2020 оны энхий 11 сарын байдлаар нийт 6521 хүнийг урьдчилан сэргийлэх багц шинжилгээний үзлэг оношилгоонд илгээсэн байна.<br><br>**Зорилт 2.Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.**<br><br>**2020 оны Шинэчлэсэн бүртгэлийг тоогоор илэрхийлэхэд:** |

| | | |
|---|---|---|
| | | • Нөхөн үржихүйн насны нийт эмэгтэйчүүд -50206<br>• Шилжин ирсэн – 105<br>• Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй – 456<br>• Оюутан – 1018<br>• Өрх толгойлсон - 184<br>• Урьдчилан сэргийлэх үзлэгт орсон эмэгтэйчүүд – 3841<br>• Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд – 1560<br>• Эмзэг бүлгийн урьдчилан сэргийлэх үзлэг – 586<br>• Орцны жижүүрүүдээс урьдчилан сэргийлэх үзлэгт орсон нь - 74<br>• Шинээр илэрсэн жирэмсэн эх -5345<br>• Эрт үеийн хяналт -89,1%<br>• 2018 оноос “Нэг цэгийн” үйлчилгээг нээж<br>✓ Зөвлөх, ахлах эх барих эмэгтэйчүүдийн эмч<br>✓ Жирэмсний хяналт 4 кабинет<br>✓ Жирэмсний дотрын эмч 2<br>✓ БЗДХӨ кабинет<br>✓ Эмэгтэйчүүдийн болон ургийн эхо харах дүрс оношлогооны эмч<br>✓ Эмэгтэйчүүдийн кабинет<br>✓ Сургалтын өрөө<br>✓ Цахим бүртгэлийн хэсэг<br>✓ Хүлээлгийн хэсэг<br>✓ Хувцасны солих өрөөг ажиллуулан 2020 онд нийт 5345 жирэмсэн эмэгтэй, эмэгтэйчүүдийн эмч 5567 удаагийн үзлэг хийж өвчлөл илэрсэн тохиолдолд эмчлэн эрүүлжүүлж ажиллаж байна.<br>• Эмчийн өдөр тутмын үзлэгийн маягтыг H.info программд бүрэн нэвтрүүлж, төрөлтийн мэдээг цаг алдалгүй авснаар нярайн болон гэрийн эргэлтийг ӨЭМТ-д төрөхөөс гарснаас 72 цагийн дотор хийж хэвшсэнээр гэрийн эргэлт хожимдохгүй, хүндрэл гарахаас сэргийлж ажиллаж байна. |

| | | |
|---|---|---|
| | | • 16-р хорооны ӨЭМТ нярайн эргэлтэндээ нярайн үнэлгээний хуудас боловсруулж ажиллаж хэвшсэнээр нярайн эмгэгийг эр хугацаанд илрүүлж дараагийн шатлалд илгээж байна.<br>• Хан уул дүүргийн 21 хорооны нийт Өрхийн эмнэлэгийн эмч нар 2020 оны шинэчилсэн бүртгэл ,ажлын үзүүлэлт хэрэгжилт,чанараар өөрсдийгөө үнэлэх зэрэг ажил хэрэгжиж үр дүнтэй явж байна.<br>• Өрхийн эрүүл мэндийн төвийн 15-49 насны нөхөн үржихүйн эмэгтэйчүүд, жирэмсэн эмэгтэйчүүдийн судалгааг жил бүр шинэчлэн гаргаж, хяналт тавин ажиллаж байна<br>• Умайн хүзүүний өмөн илрүүлэх эсийн шинжилгээнд хамрагдах зорилтот бүлгийн 30-60 насны 10096 эмэгтэйгээс 3728 /37%/, 20-с дээш насны 43257 эмэгтэйгээс 33743 /78%/ хамрагдаж өмнөх оноос умайн хүзүүний эсийн шинжилгээний хамрагдалт 1%, хөхний өмөнгийн илрүүлэг 18%-иар өссөн.<br>• 2020 онд умайн хүзүүний эсийн шинжилгээнд өөрчлөлттэй илэрсэн 95 хүнээс 39-ийг ХСҮТ-ийн эх барих эмэгтэйчүүд, хавдрын эмчид илгээн, 52 ASCUS гарсан эмэгтэйг ХУЭМТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч хяналтандаа авч нийт 47 эмэгтэйг эмчлэн эрүүлжүүлсэн байна<br>• Умайн хүзүүний хавдар илрүүлэх эсийн шинжилгээнд өөрчлөлттэй гарсан эмэгтэйчүүдийн умайн хүзүү дурандах дуранд засвар үйлчилгээ хийж, шаардлагатай багаж, уусламыг аван, хүний нөөцийг ХСҮТ-ийн эмэгтэйчүүдийн тасагт 10 хоног дагалдан ажиллуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Үйл ажиллагаа 2021 оноос жигдэрснээр иргэдэд тусламж үйлчилгээ ойртоно.<br>• 2020 оны 04 сарын 20 ны өдөр НҮЭМ-ийн хөтөлбөрийн хүрээнд өрхийн эрүүл мэндийн төвийн хяналтанд байгаа жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналтыг хяналт үнэлгээний хуудсаар үнэлэн шалгаж, хяналт, дүгнэлт хийн ажиллаж байна.<br>• Эх барихын эмч нар болон Өрхийн эмнэлэгийн жирэмсний хяналтын эмч нарын дунд ижил мэргэжилтний үнэлгээ тогтмол хийж, хяналтын картанд үнэлгээ өгөх, 318-р тушаалын дагуу үзлэг хийж, зөвлөгөө өгч буй эсэхэд улирал тутам хяналт тавин ажиллаж байна.<br>• ХУЭМТ, ХУ яармаг салбарын эх барих эмэгтэйчүүдийн эмч нар сар бүр ижил мэргэжилтний үнэлгээ хийж илэрсэн алдаа зөрчлийг хэлэлцэн дахин давтагдахаас |

сэргийлэх, ХУЭМТ-ийн Чанарын албанаас улирал тутам дотоод хяналт, үнэлгээ хийж гарах эрсдэл, хүндрэлээс сэргийлэх, мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч байна.

- ЭМЯ-ны төслийн хүрээнд 10 сая төгрөгийн үнэ бүхий ургийн зүрхний бичлэгийн аппарат 2, гар электрон допплер 1, жин, хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат 1, суурин даралтны аппарат 1-ийг авч Нэг цэгийн тусламж үйлчилгээнд ашиглаж, жирэмсний хяналтын чанар сайжирч, амьгүй төрөлтөөс сэргийлж байна

**Сайжирсан үзүүлэлт:**

1. Хяналтгүй төрөлт 8 тохиолдол, гэрийн төрөлт 8 тохиолдол, амьгүй төрөлт 19 тохиолдол бүртгэгдсэн 2019 оноос буурсан үзүүлэлттэй.
2. 0-1 насны хүүхдийн эндэгдэл 2019 оноос 10, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 1, гэрийн төрөлт 2, хяналтгүй төрөлт 6 тохиолдлоор буурч, амьгүй төрөлт мөн оны үетэй дүйцэж байна. Үндсэн үзүүлэлтүүд хотын дунджаас доогуур байна.
3. Эхийн эндэгдэл 1. Эх барихын шууд бус шалтгаантай ходоодны хорт хавдар төгсгөлийн шатандаа оношлогдож олон эрхтэнд үсэрхийлэл өгснөөр эхийн эндэгдэл хүргэх шалтгаан болж, жирэмсний 27-28 долоо хоногтойд төрөлтийг төрөх замаар шийдсэн. Хотын дунджаас доогуур үзүүлэлттэй байна.
4. Хоног болоогүй нас баралт гараагүй
5. Тэмбүү өвчин өмнөх оноос 22 тохиолдлоор нэмэгдсэн, тэмбүүтэй жирэмсэн 44 тохиолдол бүртгэгдэж эмчилгээнд бүрэн хамрагджээ.
    - Өсвөр үеийн кабинеттай, Хүнсний коллежын Дэггүй өсвөр нас оюутны клубтэй хамтран тус коллежийн оюутаннуудад сургалт хийлээ. Тус сургалтанд Сэтгэцийн эрүүл мэнд , Наркологийн кабинетаас "Өсвөр үеийнхний стресс" сэдвээр хийсэн ба стресс түүний ангилал, өсвөр үеийнхэнд зонхилон тохиолдох стрессүүдийн талаар болон стресс тайлах арга, зөвлөмжийн талаар мэдээлэл хийж стресс тайлах энгийн дасгалыг заалаа. Тус сургалтанд нийт 150 оюутан залууст цахимаар мэдээ мэдээлэл өгсөн. хамрагдсан байна.
    - Монгол Улсын Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн10 дугаар зүйл, Эрүүл мэндийн сайдын А/480, А/739 дугаар хамтарсан тушаал Нийслэлийн Эрүүл Мэндийн Газрын 2020 оны 09 сарын 24-ний 2/655 албан тоотыг тус тус хэрэгжүүлэх үүднээс мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд оюутны

| | | |
|---|---|---|
| | | эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, өвчлөлийг эрт илрүүлэх үзлэгийг 2020 оны 10 сараас 2020 оны 11 дүгээр сарын 10-ны хооронд Монгол солонгосын хамтарсан политехник, ШУТИС-ын механик инженерийн сургуулийн 562 охидод үзлэг шинжилгээ, 1880 оюутанд ДОХ/тэмбүү илрүүлэх шинжилгээ хийж эмчлэн эрүүлжүүлэх ажил зохион байгуулсан.<br>• 2020 онд 35 – с дээш насны 1237 эхийг ЭХҮМЭТ-ийн перинаталь оношлогоонд илгээсэн. Мөн шинээр хяналтанд орсон 4198 эхийг /NT/ үзүүлэх ЭХО шинжилгээнд хамруулан 2,3 тест өгч ургийн гажгийг илрүүлэн оношлож байна. Гажигтай илэрсэн эхчүүдийг ВКК-д оруулж шийдүүлсэн . нийт 27<br><br>Ургийн болон нярайн төрөлхийн гаж хөгжлийг илрүүлэх зорилгоор жирэмсэн эхчүүдийг<br><br>• PCR, TORCH халдварын шинжилгээнд эрсдэл ихтэй жирэмсэн эхийг хамруулж байна.<br>• NT хэмжих ЭХО оношлогоонд жирэмсэн эхчүүдийг хамруулан ажиллаж байна.<br><br>Үүнээс :<br><br>Төрөлхийн гажигтай нярай 3 төрсөн. /төрөлхийн Дауны синдром,эдвардис синдром/ |
| | | **Зорилт 3. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.**<br><br>Халдварт бус өвчний эрсдэл болон хүндрэлээс урьдчилан сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол зорилгоор ЭМТ, ӨЭМТөвүүд 2020 онд нийт 1566 удаагийн цахим сургалт, сурталчилгаа мэдээллийг хийсэн.<br><br>Жилийн эцсийн байдлаар Артерийн даралт, чихрийн шижний эрт илрүүлэгийн үзлэгт 18-аас дээш насны нийт 112,849 хүнийг хамруулахаас 60.2%-ийг буюу 67982 хүнийг |

| | | |
|---|---|---|
| | | хамруулсан. Үүнээс давтан үзлэгт 10282 хүн хамрагдаж батлагдсан артерийн даралт 166 байна. Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг зорилтот бүлгийн 10096 хүн хамруулахаас 37%-ийг буюу 3728 хүнийг хамруулсан. Хөхний хавдрын эрт илрүүлэг үзлэгт зорилтот бүлгийн 43257 хүн хамрагдахаас 78%-ийг буюу 33743 хүнийг хамруулсан.<br><br>Чихрийн шижин хэв шинжийн 2 эрт илрүүлэг үзлэгт нийт 59330 хүн хамрагдсанааас 24778 эрэгтэй, 34552 эмэгтэй хүн хамрагдаж батлагдсан чихрийн шижин 12 байна. |
| | | Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын үйл ажиллагааг тогтмолжуулж үзүүлэлтийг сайжруулах чиглэлээр:<br><br>1. 2020 онд Нийтийн биеийн тамир, бясалгал, иог, зохистой хөдөлгөөн /фитнес/-ээр хичээллэх өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулах магадлан итгэмжлэлд ХУД-ийн хэмжээнд Магадлан итгэмжлэл хийх хараат бус шинжээчдийн багийг ХУД-ийн БТС хорооны даргын тушаалаар ХУД-ийн БТСХ, ЭМТ хамтарсан хараат бус шинжээчдийн баг байгуулан ажиллаж байна.<br>2. ХУД-ийн магадлан итгэмжлэлийн хараат бус шинжээчдийн баг ХУД-т байрлах 3 фитнессийн төвд өөрсдийн хүсэлтээр /Соёл фитнесс, Эмпайр, Олимфус фитнесс /очиж халдвар хамгаалал, бичиг баримт хөтлөлт, орчны стандартын дагуу зөвлөгөө өгч ажилласан.<br>3. ХУД-т байрлах 3 фитнесс магадлан итгэмжлэлд хамрагдаж гэрчилгээгээ авсан. ХУД-ийн иргэдэд чийрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. ЭМТ, БТСХ хамтран зөвлөгөө өгч ажиллаж байна.<br>4. ХУЭМТ-ийн эмч ажилчдаа чийрэгжүүлэх зорилгоор Эмпайр фитнесс төвтэй гэрээ хийн ажиллаж байна. Тус гэрээгээр 1 сарын төлбөр 50.000 болгон хөнгөлсөн. ЭМД-ийн сангаас 20.000 төг буцаан олголт олговол 1 хүн сардаа 30.000 төг фитнесст хамрагдах боломжоор хангаж ажилласан байна.<br>5. 2020.01.17-нд ХУД-ийн Био кабинетийн 250 ажилчдын ББХЧТТ сорил авч Биеийн бүтэц тодорхойлох аппаратаар тодорхойлж 250 хүн хамруулсан байна.<br>6. ББХЧТТ сорил авах аргачлал дасгал хийх зөвлөмжийн тухайн MNB суваг Спорт хэлэлцүүлэгт оролцон мэдээлэл өгсөн. |

| | | |
|---|---|---|
| | | 7. Дотоод шүүрлийн булчирхайн эмчтэй хамтран 14 хоногт 1 удаа шинээр хяналтад орж байгаа өвчтөнд хэмжилт хийн сургалт тогтмол зохион байгуулж байна.<br>8. ХУД-ийн ЭМТ, ХУД-ийн ахмадын хороо, БТС хороотой хамтран 16 хорооны ахмадуудад хийх дасгал, Аэробикийн дасгалын 7 хоногийн сургалтын зохион байлсан. Сургалтад нийт 16 хорооны 54 ахмад хамрагдсан.<br>9. “Дэлхийн алхалтын өдөрт” 10 хоногийн аяны хүрээнд байгууллагын хэмжээнд хийх ажлын төлөвлөгөө гарган ажилласан.<br>10. Дэлхийг алхалтын өдрийг Хан-Уул дүүргийн ЗДТГ, Хан-Уул Эрүүл мэндийн төв, Биеийн тамир, спортын хороо хамтран дүүргийн хэмжээнд 10 хоногийн алхалтын аяныг зохион байгуулж албан байгууллага, иргэдийг нэгдэхийг уриалан ажиллалаа. Аяны хүрээнд удирдамж гарган батлуулж аянд идэвхтэй оролцохыг уриалж зохион байгуулж оролцлоо.<br>11. 10 сарын 20-нд ХУД-ийн ЗДТГ, ХУДБТСХ, ХУЭМТ хамтран Алхалтын аяны хүрээнд ХУД-ийн ЗДТГ-ын харьяа хэлтэс албадын ажилчдад “Алхалтын ач тус”, “Дасгал хөдөлгөөнийг дадал болгоё”, “Ажлын байранд хийх дасгал”-ын сургалт хийж нийт 56 хүн хамрагдсан байна.<br>12. 10 сарын 21- нд өглөөний 07:30 цагт Төв цэнгэлдэх хүрээлэнгийн урд талбайд өглөөний дасгал хамтдаа хийж тус талбайгаас эхлэн дүүргийн ЗДТГ-н төв байр хүртэл алхалт хийж ХУЭМТ, ӨЭМТ-ийн эмч эмнэлгийн ажилчид болон ХУД иргэд “Өөрчлөлтийг өөрөөсөө “ аяны тамирчид нийт 21 хүн аянд нэгдэв.<br>13. ХУД 9, 10, 16 хороодын иргэд “ Өөрчлөлтийг өөрөөсөө “ баг тамирчид 8 хүн 10 сарын 19 - 10 сарын 21 хүртэл өдөр бүр Идэвхтэй алхалт хийж цахим сүлжээнд өдөр бүр мэдээлэл байршуулан бусдыгаа уриалж аянд 10 хоног тасралтгүй нэгдэв.<br>14. ХУД-ийн ӨЭМТ-үүд дээр 10 хоногийн аяныг эмч ажилчид болон иргэдийн дунд зохион байгуулж нийт 63 хүнийг 1260 км алхалт хийж 94.500 ккал шатааж 8.820 минут амьдралын цагийг уртасгаж, 913.5 гр өөх шатаасан байна.<br>15. 10 сарын 28 ДЭЛХИЙН АЛХАЛТЫН ӨДӨР-2020 ХУД-ийн Эрүүл Мэндийн төвийн эмч эмнэлгийн ажилчид “машинаар биш явганаар👈👉лифтээр биш шатаар” уриатай идэвхтэй алхалт хийж ажилдаа ирлээ. өнөөдөр лифт ашиглахгүй байх уриатайгаар ажлаа эхэллээ. идэвхтэй алхаж ажилдаа ирсэн эмч ажилчдаа үүдэнд угтан авч витаминаар дархлааг нь дэмжин, алхалтын ач тусыг сурталчлав. |

| | | |
|---|---|---|
| | | 16. 10 сарын 28 дэлхийн алхалтын өдөр-2020 худ-ийн өэмт-үүд алхалтын аянд нэгдэн байгууллага бүр арга хэмжээ зохион байгуулсан. Нийт 150 хүн амруулан арга хэмжээ зохион байгуулсан байна.<br><br>**Зорилт 1: Хүн амыг хепатитийн вирусын халдвараас сэргийлэх, эрсдэлт зан үйлийг өөрчлөх, дархлаажуулалтыг өргөжүүлэх, мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх замаар халдварын тандалт, хяналтын тогтолцоог бэхжүүлнэ.**<br><br>“2020 оны эхний 10 сарын байдлаар Хепатит А вирусын эсрэг товлолт дархлаажуулалтын 1-р тунд хамрагдвал зохих 3878 хүүхдээс 3855 хүүхдийг хамруулж хамралтын хувь-99.4%, 2-р тунд хамрагдвал зохих 3789 хүүхдээс 3764 хүүхдийг хамруулж хамралтын хувь-99.4% байна. А вирусын эсрэг дархлаажуулалтын 1,2-р тунгаас хоцорсон 695 хүүхдийг нөхөн дархлаажуулсан байна.<br><br>2020 оны эхний 10 сард В гепатитын эсрэг вакцины 1,2-р тунд 8 хүнийг, 3-р тунд 39 хүнийг тус тус хамруулсан ба 2020 оны эхний 10 сарын байдлаар нийт эмч эмнэлгийн ажилчдын В гепатитын эсрэг вакцины дархлаажуулалтад хамрагдалт 90.5 % -тай байна.<br><br>ЭМТ-ийн хэмжээнд С вирусын халдвартай 23, В вирусын халдвартай 16 эмч ажилтнуудаас вирусын ачаалал ихтэй 1 эмч ажилтныг эмчилгээнд хамруулсан. Элэгний В,С вирусын эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэдээс сайн дураараа хепатит В-вирусын эсрэг дархлаажуулалтад хамрагдах хүсэлтэй иргэдийг ХУЭМТ-ийн дархлаажуулалтын кабинетад дархлаажуулалтад хамруулах ажлыг хийж байгаа бөгөөд 1-10 дугаар сард 1-р тунд 1867 хүн, 2-р тунд 1696, 3-р тунд 2049 хүн буюу нийт 4612 хүн/тун вакцинд хамруулсан байна.<br><br>ЭМТ-ийн эрүүл мэндийн даатгалын мэргэжилтэн болон ӨЭМТ –үүд Зорилтот насны иргэдийг www.health.gov.mn цахим хуудсанд асуумж, илрүүлэг шинжилгээ гэсэн дараалаар илрүүлэг шинжилгээнд хамрагдсан иргэн бүрийн мэдээллийг бүртгэж мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна. 2017-2020 онд нийт 64372 иргэнийг илрүүлэг, шинжилгээнд хамруулсан бөгөөд үүнээс 2020 оны эхний 10 сард 10743 иргэн хамрагдсан. |

| | | |
|---|---|---|
| | | Хорт хавдрын шинэ өвчлөлүүдийг CANREGMON программ, H-Info программуудад шивж мэдээллэж байна. ӨЭМТ-үүдэд ХУХЭИ-н шинэчлэгдсэн программыг үргэлжлүүлэн сургаж дэмжлэгт хяналт хийн ажиллаж байна.<br><br>**Зорилт 2: Үндэсний хэмжээнд хепатитийн вирусын халдвар, элэгний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний нотолгоонд тулгуурласан чанартай багц тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлнэ.**<br><br>Вируст хепатит өвчний 11 тохиолдол бүртгэгдсэнээс ВГС тохиолдол гараагүй. ВГА 1, ВГВ 10 тохиолдол гарсан бөгөөд өмнөх оны мөн үеэс нийт ВГ 6 тохиолдол, 0.5 промилээр буурсан байна.<br><br>"Элэг бүтэн монгол хөтөлбөр"-ийн хүрээнд 2017-2019 онд зорилтот насны 121011 иргэнийг үзлэгт хамруулахаас 64372 /53.2%/ иргэд үзлэгт хамрагдсан. 2020 оны эхний 10 сарын байдлаар 10743 иргэд эрт илрүүлэгт хамрагдаад байна. 2020 оны эхний 10 сард илрүүлэгт хамрагдсан иргэдээс 607 В вирустэй илэрснээс вирусын ачаалал тоолуулсан-186, эмчилгээнд хамрагдсан-134 /22.1%/, С вирустэй 793 иргэнээс вирусын ачаалал тоолуулсан-263, үүнээс эмчилгээнд орсон 240 /33.2%/ байна. Эмчилгээнд орсон С вирустэй иргэдийн 100% нь бүрэн эмчлэгдсэн байна.<br><br>Дүүргийн хэмжээнд вируст хепатитын эмчилгээ бичих эрх бүхий 5 эмч ажиллаж байна.<br><br>Мөн шинээр хяналтад орсон нийт 5002 жирэмсэн эмэгтэйг эрт илрүүлгийн шинжилгээнд хамруулан ажилласан. Үүнээс В вирустай-95, С вирустай-82 жирэмсэн эмэгтэй байна. В вирусын эмчилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо 42 байна.<br><br>ЭМТ-ийн хэмжээнд ажиллаж байгаа цусаар дамжих халдвартай /В,С вирустэй/ эмч ажилтнуудын судалгааг шинэчлэн гаргаж ажилчдын эмчид хүргүүлэн хяналтанд авахуулан эмчилгээний асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. ЭМТ-ийн В вирустай 1 ажилтныг эмчилгээнд хамруулж байна.<br><br>21 хорооны ӨЭМТөвийн хэмжээнд ВГВ-тай 21, ВГС-тай 25 эмч эмнэлгийн ажилтан байна. Бүх ажилчид элэгний D вирусын шинжилгээнд хамрагдаагүй учир хавсарсан халдварыг |

| | | |
|---|---|---|
| | | тодорхойлох боломжгүй байна. Одоогийн байдлаар дархлал тогтцын шинжилгээнд хамрагдсан ЭМТ-ийн 50, ӨЭМТ-ийн 29 буюу нийт 79 эмч, эмнэлгийн ажилчид байна.<br><br>ӨЭМТ-д: 2 сарын 17-оос 3 сарын 13-ны өдрийн хооронд ЭМТ-д В,С вирусын илрүүлэг, шинжилгээ хийж ажиллаж байгаа ӨЭМТ-үүдийн сувилагч нарт ЭМТ-ийн лабораторийн эрхлэгч Ё.Бумдарь эмч болон тус кабинетийн 4 лаборантын хамт хяналт хийж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.<br><br>ӨЭМТ-ийн удирдлага болон Чанарын баг-ийн зүгээс В,С вирусын эрт илрүүлгийн сорьц авах өрөөг стандартын дагуу зохион байгуулан ажиллаж, сорьц авахад шаардлагатай нэг удаагийн хэрэгсэл, аюулгүй хайрцаг, наалт зэргээр хангаж ажилласан.<br><br>ЭМС-н 536 тушаалд заасны дагуу өртөлтийн дараах цомгийг сорьц авж буй өрөөнд, сорьц авагчийн тоогоор байрлуулж халдвараас авах эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.<br><br>2020 оны 1-р сарын 14-нд ЭМТ-ийн Дотрын их эмч Л.Мэдэхгүй элэгний В, С вирусын хор уршиг, элэг өвчилбөл ямар аюулд хүргэх, эрүүл зөв хооллолтын ач тусыг эмч нар болон, иргэдэд хүргэх зорилгоор “Амгалан-өрх” ӨЭМТ-д сургалт зохион байгуулж, сургалтад 32 хүн хамрагдсан.<br><br>“Элэг бүтэн монгол хөтөлбөр”-ийн хүрээнд 2017-2019 онд зорилтот насны 121011 иргэнийг үзлэгт хамруулахаас 64372 /53.2%/ иргэд үзлэгт хамрагдсан. 2020 оны эхний 10 сарын байдлаар 10743 иргэд эрт илрүүлэгт хамрагдаад байна. 2020 оны эхний 10 сард илрүүлэгт хамрагдсан иргэдээс 607 В вирустэй илэрснээс вирусын ачаалал тоолуулсан-186, эмчилгээнд хамрагдсан-134 /22.1%/, С вирустэй 793 иргэнээс вирусын ачаалал тоолуулсан-263, үүнээс эмчилгээнд орсон 240 /33.2%/ байна. Эмчилгээнд орсон С вирустэй иргэдийн 100% нь бүрэн эмчлэгдсэн байна.<br><br>**Зорилт 3: Хепатитийн вирусын халдварын өвчлөл, элэгний хорт хавдрын үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.** |

| | | |
|---|---|---|
| | | БЗДХ/ХДХВ/ДОХ-ын кабинетаас 2020 оны эхний 11 сарын байдлаар ХУД-ийн Засаг даргын захирамж гарган Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр, Тэмбүүг устгая, Элэг бүтэн Монгол аяны хүрээнд ХУДЗДТГ-ын дэргэдэх алба хэлтэс, ХУД-ийн хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд нийт 70 байгууллагын 3946 ажилтан албан хаагчдыг шинжилгээнд хамрууллаа.<br><br>**Сэтгэц наркологийн чиглэлээр:**<br><br>**Зорилт 1. Иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх.**<br>Иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 20 ӨЭМТөвтэй хамтран нийт 34 удаагийн мэдээлэл сургалт хийж давталттай тоогоор 42263 иргэнийг мэдээллээр ханган ажилласан.<br><br>ХУЭМТ-н ажилчдын дотоод групп болон Хан- Уул эрүүл мэндийн төвийн пейж хуудсан дээр тамхины хор уршигийн талаархи мэдээлэл, дам тамхидалтын талаар видео хичээл байрлуулсанг 591 хүнд хүрсэн байна.<br><br>Кабинетаар үйлчлүүлж буй иргэдэд тамхины хор уршигийн талаархи мэдээлэл, сургалт сурталчилгаа нийт 219 хүнд хийсэн байна.<br><br>Мэдээлэл зөвлөгөө өгөх самбар дээр тамхины хор уршигийн талаарх мэдээ, мэдээлэл, зөвлөмж байршууллаа<br>**Зорилт 2. Холбогдох албан хаагчдыг мэргэшүүлэх, орчин үеийн шинэ технологи нэвтрүүлэх.**<br>Холбогдох албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр 2020 оны 1 дүгээр сарын 17 нд Иргэний агаарын тээврийн цагдаагийн албан хаагчдад "Тамхины хор уршиг дам тамхидалт" сэдэвт сургалтыг хийсэн. Нийт 39 хүн хамрагдсан.<br>Иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 20 ӨЭМТөвтэй хамтран нийт 34 удаагийн мэдээлэл сургалт хийж давталттай тоогоор 42263 иргэнийг мэдээллээр ханган ажилласан. |

<table>
<tr><td></td><td></td><td>“Мансууруулах эм сэтгэц нөлөөт бодисын давхар хамааралтай хүн гэж ямар хүнийг хэлэх вэ? Тамхидалт дам тамхидалтгүй шинэ үе, Дэлгэцийн донтолт, Сэтгэлзүйн дархлаа дэмжих зөвлөгөө, Уур бухимдалт, стресс, Сэтгэц мансууруулах эмийн жор хяналт” сэдвүүдээр цахим сургалтыг 42263 хүнд, Холбогдох албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр 2020 оны 1 дүгээр сарын 17 нд Иргэний агаарын тээврийн цагдаагийн албан хаагчдад “Тамхины хор уршиг дам тамхидалт” сэдэвт сургалтыг хийсэн. Нийт 39 хүн хамрагдсан.<br><br>Covid19-тэй холбогдуулан онлайн сургалтын аргачлалыг ӨЭМТөвүүдийн нийгмийн ажилтнуудтай хамтран зохион байгуулж нэгдсэн сургалтын нэг системтэй боллоо. Уг нэгдсэн сургалтын санг нийт ажилчид ашиглах боломжтой бөгөөд иргэдэд давталттай тоогоор сургалт мэдээлэл хийж хэвшээд байна. Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын 29 сургалтын материал бичлэгийг бэлтгэн оруулж дүүрэгтээ ашиглаж байна. Линк: https://drive.google.com/drive/folders/189w2P80EaX9C5kAJTxQFZGdOZNC2P0Et</td></tr>
<tr><td></td><td></td><td>Зорилт 4. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакцинийг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.<br><br>Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр “Тэмбүүг устгая “ аяны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br><br>ХДХВ/ДОХ/БЗДХ-ын кабинетын үйл ажиллагаа:<br><br>• Бүгд үзлэг-18794<br>• Кабинетын урьдчилан сэргийлэх үзлэг- 15713<br>• Диспансерын хяналт – 2831<br>• Бусад үзлэг /өвчний учир амбулаторт, дуудлага/- 1709<br>• Жирэмсэн-3750<br>• Орон гэргүй -155<br>• Багцын үзлэг - 6066<br>• Идэвхитэй эрт илрүүлэг – 5960 үүнээс тэмбүү зэрэг гарсан 121</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | • Онош батлагдаж эмчилгээнд хамрагдсан: 160<br>Нийт БЗДХ-т өвчин - 268 Үүнээс:<br>Тэмбүү – 160 буюу 59,7%<br>Заг хүйтэн – 39 буюу 14,5%<br>Трихомониаз – 47 буюу 17,5%<br>Бусад -22 буюу 8,3% тус тус эзэлж байна.<br><br>ХУДЗДТГ-ын дэргэдэх хэлтэс албад, ХУД-ийн хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд нийт 70 байгууллагын 3946 ажилтан албан хаагчдыг, Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран нэг цэгийн үйлчилгээгээр цусаар дамжих халдвар элэгний В,С-ийн шинжилгээ Тэмбүү ХДХВ илрүүлэх шинжилгээ зөвлөгөөнд **262** хүнийг, Орон гэргүй архины хамааралтай эмзэг бүлгийн **155** хүнийг, Эрсдэлт зорилтот бүлгийн хүн ам болох уул уурхайн салбарт ажиллаж байгаа болон, алсын тээврийн жолооч Мон Армор уул уурхайн компанийн жолооч, ажилчид **115** хүнийг тус тус үзлэг, шинжилгээнд хамрууллаа.<br><br>Зорилтот бүлгийн хүн ам болох өсвөр насны оюутан сурагчдыг БЗДХ-аас сэргийлэх сургалтыг Монгол Солонгосын Политехникийн Коллежийн 1270 оюутанд “БЗДХӨ гэж юу вэ урьдчилан сэргийлэх нь” сэдвээр 1270 оюутан, Механик тээврийн сургуулийн МСҮТ-ийн 933 оюутан нийт 2203 оюутанд сургалт зохион байгуулж гарын авлага тараасан.<br><br>7. Зорилтот бүлгийн хүн ам болох өсвөр насны оюутан сурагчид Монгол Солонгосын Политехникийн Коллежийн **1270** оюутан, Механик тээврийн сургуулийн МСҮТ-ийн **933** оюутан нийт **2203** оюутаныг Бэлгийн замаар дамжих халдвар илрүүлэх тэргэвчилсэн тестын шинжилгээнд хамруулж МСПК –оос тэмбүү 5 илэрч үүнээс шинэ халдвар 4 хуучин халдвар 1 илэрч ийлдэс судлалын шинжилгээгээр баталгаажуулж хяналтанд авч эмчилгээнд оруулж эрүүлжүүлсэн.<br><br>Механик тээврийн сургуулийн **933** оюутанаас тэмбүүгийн халдвартай **4** шинэ халдвар, заг хүйтэн **1** илэрч эмчилгээнд хамрагдаж эрүүлжүүлж хяналтанд авсан. |

**Хан-Уул дүүргийн хэмжээнд дархлаажуулалт**

**Товлолт дархлаажуулалт**: 2020 оны эхний 10 сараар /бүрэн тунгаар

| Вакцины нэр | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Хувь |
|---|---|---|---|
| **Тавт3 Саа4** | 4475 | 4458 | 99.6% |
| **УГУ1** | 4283 | 4260 | 99.4% |
| **Агепатит1** | 3878 | 3855 | 99.4% |
| **УГУ2, Агеп2** | 3789 | 3764 | 99.3% |
| **ПЭВ1** | 4567 | 4555 | 99.6% |
| **ПЭВ2** | 4476 | 4459 | 99.6% |
| **ПЭВ3** | 4089 | 4066 | 99.4% |
| **Сахуу,татран** | 6792 | 6781 | 98.9% |

2020 оны эхний 10 сарын байдлаар товлолын дархлаажуулалтаас хоцорсон хүүхдүүдийг ЭМС-ын 261 дугаар тушаалын дагуу нөхөн дархлаажуулалтанд хамруулах ажлыг зохион байгуулж Сүрьеэгийн вакцинд -22, Тавт, саа-1148, УГУ -890,А гепатит-695, ПЭВ-1185 хүүхдийг тус тус хамруулсан байна

Өнгөрсөн оны мөн үеэсээ амьсгалын замын өвчлөлүүдээс Салхин цэцэг-23.4, улаан эсэргэнэ-3.4, гахайн хавдар- 0.1 промилоор тус тус буурсан байна.

**Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд чанартай үзүүлэхийн тулд дүүргийн эрүүл мэндийн салбарт ажиллагсадын тоог үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээ, Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж, хүний нөөцийг чадваржуулах зорилтын хүрээнд:**

Хан-Уул эрүүл мэндийн төв нь 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 222 ажилтантай ажиллаж байгаагаас удирдах ажилтан 11, их эмч 62, сувилагч, тусгай мэргэжилтан 73, эмнэлгийн бусад ажилтан 76, гэрээт ажилтан 5 тус тус ажиллаж байна. Нийт эмч мэргэжилтний 199 нь эмэгтэй, 23 нь эрэгтэй ажилтан байна. Нийт ажилчдын 35% 20-39 насны, 52,3% 40-54 насны, 13% 55-аас дээш насны эмч, ажилчид байна.




Боловсролын зэргийн байдлаар авч үзвэл: магистр 17 , бакалавр 125 , дипломын 47, тусгай дунд 8, бүрэн дунд боловсролтой ажилтан 25 байна.

Мэргэжлийн зэргээр ангилбал: клиникийн профессор 7, ахлах зэрэгтэй 41, тэргүүлэх зэрэгтэй 2 ажилтан байна.

Албан хаагчдын мэдлэг, мэрэгшлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт Хүлээн авах яаралтай тусламжийн их эмчээр Өсвөр үеийн их эмч Оюунцэцэг.

1. Хөнгөвчлөх хими эмчилгээний 6 сарын курс- их эмч Б.Үүрцайх,
2. Гемодиализын сувилагчийн мэрэгшүүлэх сургалтанд сувилагч Дугармаа
3. Сувилагч мэргэжлээр Туслах сувилагч Д.Нямдаваа
4. Мэс заслын боолтны сувилагчаар сувилагч Р.Отгончимэг

5. Ахмадын эмч Ч.Ганцэцэг –Гернтологийн төвд “Настны эмгэг судлал” чиглэлээр 6 сарын нарийн мэргэжил олгох сургалтанд
6. 2020 оны 02 дугаар сард эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” сэдвээр 1 кредитийн сургалт зохион байгуулсан бөгөөд 134 хүн хамрагдсан.





7. Тархвар судлаач Б.Цэндсүрэн, Хулан, Хоролсүрэн нар Сэтгэл засал судлал төрөлжсөн мэргэжил, Тархвар судлал судлалын 6-н сарын олгох курст тус тус суралцаж байна.
8. Ариунсайханыг байгууллагын захиалгаар Хүүхдийн их эмчийн резидентийн сургалт
9. Ковид-19 халдварын үеийн тусгайрлах өрөөнд ажиллах эмч мэргэжилтнийг мэргэшүүлэх сургалт - Намуунбайгаль, Гэрэлт-Од, Мөнгөнсэлэнгэ
10. Харвалт шигдээсийн нэгж байгуулах багийн мэргэшүүлэх сургалт- Намуунбайгаль, Мөнхдэлгэр, Мөнгөнсэлэнгэ
11. АШУҮИС-ийн тархи судлалын хүрээлэн дэлхийн тархи судлалын байгууллагын Ази-Номхон далайн бүсийн хороотой хамтран “Нейросайнсын үндсэн техникүүд” сэдэвт ОУ сургалтад сэтгэцийн их эмч Л.Хоролсүрэнг хамруулав.
12. 2020 оны 01 сарын 22 ны өдрийн “Шинэ короновирусийн халдварын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах тухай ЭМС-ын 19 дугаар бүхий албан даалгаврыг хэрэгжүүлэн халдвараас өөрсдийгөө хамгаалах дадал эзэмших сургалт зохион байгуулав.

| | | |
|---|---|---|
| | | 13. Хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх тайлах дадлага сургуулилтад 190 эмч мэргэжилтэн хамрагдсан.<br>  <br> <br>14. 2020.09.08-ны өдөр Гурван ухаан эрин ТББ-тай хамтран ЭМТ-ийн 35 ажилтанд хувь хүн, ажилтны ёс зүйг дэмжих сургалтыг зохион байгуулсан.<br>15. 2020.09.25 Шинэ ажилтны чиглүүлэх сургалтыг ёс зүйн хороотой хамтран явууллаа.<br>16. Сөүл хотын захиргаа болсон Сөүл аялал жуулчлалын газрын “Гадаад эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг Солонгос эмнэлгүүдэд сургах, туршлага солилцуулах-2020” төсөл Вонгуаны их сургуулийн Монгол дахь төлөөлөгчийн газар болон НЭМГ-ын хамтын ажиллагааны хүрээнд болох 8 долоон хоногийн сургалтад шүдний их эмч Г.Төрбатыг суралцуулахаар материалыг бүрдүүлэн өгч, явахаар төлөвлөөд байна. |
| | | **Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага болон мэргэжлийн байгууллагуудтай сургалт, уулзалт зохион байгуулж хамтран ажиллах зорилтын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:** |

**Зорилт 1: Хүн амын зорилтот бүлгүүдийн сонирхол, бодит хэрэгцээнд нийцсэн биеийн тамир, спортын үйл ажиллагаа, бие бялдрын боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх**

- ХУЭМТ-ийн эмч ажилчдаа чийрэгжүүлэх зорилгоор Эмпайр фитнесс төвтэй гэрээ хийн ажиллаж байна. Тус гэрээгээр 1 сарын төлбөр 50.000 болгон хөнгөлсөн. ЭМД-ийн сангаас 20.000 төг буцаан олголт олговол 1 хүн сардаа 30.000 төг фитнесст хамрагдах боломжоор ханган ажилласан байна.
- Хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 1 сарын 10-нд ХУД-ийн ЭМТ, БТС хороо хамтран спорт хамтлагуудын дунд спортын 3 төрлийн тэмцээн зохион байгуулсан. Тэмцээнд 13 байгууллагын 190 гаруй албан хаагчид хамрагдсан.
- 2020 оны 1 сарын 15-нд ХУД-ийн ЭМТ-ийн эмч ажилчдын дунд спортын 3 төрөлт тэмцээн зохион байгуулагдаж аваргуудаа тодруулсан. 3. Нийслэлийн эрүүл мэндийн газрын нэрэмжит 5 төрөлт тэмцээнд баг бүрдүүдэн оролцож шатрын төрөлд эрэгтэй 4-р байр, эмэгтэй хүрэл медаль хүртсэн амжилт гаргасан. Багийн дүнгээр 15-р байр эзэлсэн.
- ХУД-ийн ЭМТ, ХУД-ийн ахмадын хороо, БТС хороотой хамтран 16 хорооны ахмадуудад хийх дасгал, Аэробикийн дасгалын 7 хоногийн сургалтын зохион байлсан. Сургалтад нийт 16 хорооны 54 ахмад хамрагдсан.
- 15. Нийслэлийн Иргэдийн спортын их наадамд ХУД-ийн хийн дасгал аэробикийн тэмцээнд баг бэлтгэн оролцож хийн дасгалын ахмадын төрөлд багаараа мөнгөн медаль хүртсэн.
- Ахмадын баярыг угтан ахмадын кабинеттай хамтран Ой тогтоолтоо хэрхэн сайжруулах вэ? Гэсэн сэдвээр хичээл заасан.
- "Дэлхийн алхалтын өдөрт" 10 хоногийн аяны хүрээнд байгууллагын хэмжээнд хийх ажлын төлөвлөгөө гарган ажилласан.
- Дэлхийг алхалтын өдрийг Хан-Уул дүүргийн ЗДТГ, Хан-Уул Эрүүл мэндийн төв, Биеийн тамир, спортын хороо хамтран дүүргийн хэмжээнд 10 хоногийн алхалтын аяныг зохион байгуулж албан байгууллага, иргэдийг нэгдэхийг уриалан

| | | |
|---|---|---|
| | | ажиллалаа. Аяны хүрээнд удирдамж гарган батлуулж аянд идэвхтэй оролцохыг уриалж зохион байгуулж оролцлоо.<br>➢ 10 сарын 20-нд ХУД-ийн ЗДТГ, ХУДБТСХ, ХУЭМТ хамтран Алхалтын аяны хүрээнд ХУД-ийн ЗДТГ-ын харьяа хэлтэс албадын ажилчдад "Алхалтын ач тус", "Дасгал хөдөлгөөнийг дадал болгоё", "Ажлын байранд хийх дасгал"-ын сургалт хийж нийт 56 хүн хамрагдсан байна.<br>➢ 10 сарын 21- нд өглөөний 07:30 цагт Төв цэнгэлдэх хүрээлэнгийн урд талбайд өглөөний дасгал хамтдаа хийж тус талбайгаас эхлэн дүүргийн ЗДТГ-н төв байр хүртэл алхалт хийж ХУЭМТ, ӨЭМТ-ийн эмч эмнэлгийн ажилчид болон ХУД иргэд "Өөрчлөлтийг өөрөөсөө " аяны тамирчид нийт 21 хүн аянд нэгдэв.<br>➢ ХУД 9, 10, 16 хороодын иргэд " Өөрчлөлтийг өөрөөсөө " баг тамирчид 8 хүн 10 сарын 19 - 10 сарын 21 хүртэл өдөр бүр Идэвхтэй алхалт хийж цахим сүлжээнд өдөр бүр мэдээлэл байршуулан бусдыгаа уриалж аянд 10 хоног тасралтгүй нэгдэв.<br>➢ ХУД-ийн ӨЭМТ-үүд дээр 10 хоногийн аяныг эмч ажилчид болон иргэдийн дунд зохион байгуулж нийт 63 хүнийг 1260 км алхалт хийж 94.500 ккал шатааж 8.820 минут амьдралын цагийг уртасгаж, 913.5 гр өөх шатаасан байна.<br>➢ 10 сарын 28 ДЭЛХИЙН АЛХАЛТЫН ӨДӨР-2020 ХУД-ийн Эрүүл Мэндийн төвийн эмч эмнэлгийн ажилчид "машинаар биш явганаар👈👉лифтээр биш шатаар" уриатай идэвхтэй алхалт хийж ажилдаа ирлээ. өнөөдөр лифт ашиглахгүй байх уриатайгаар ажлаа эхэллээ. идэвхтэй алхаж ажилдаа ирсэн эмч ажилчдаа үүдэнд угтан авч витаминаар дархлааг нь дэмжин, алхалтын ач тусыг сурталчлав.<br>➢ 10 сарын 28 дэлхийн алхалтын өдөр-2020 худ-ийн өэмт-үүд алхалтын аянд нэгдэн байгууллага бүр арга хэмжээ зохион байгуулсан. Нийт 150 хүн амруулан арга хэмжээ зохион байгуулсан байна.<br>➢ Алхалтын аяны хүрээнд 8 төрлийн сурталчилгааны материал гарган ЭМТ-ийн эмч ажилчид болон ӨЭМТ-үүдэд гарын авлага болгон хангав.<br>➢ ХУД-ийн Алхалтын аян групп, ХУЭМТ-ийн дотоод групп, ӨЭМТ-үүд групп, ӨЭМТ-үүдийн группүүдэд алхалтыг сурталчилсан сурталчилгааг тогтмол хийсэн.<br>➢ ХУД-ийн 3-р хороонд байрлах 43 байрны "Шарав 43" СӨХ-тай хамтран тухайн байрны орох гарах үүд, лифт, шит, мэдээллийн самбарт алхалтыг сурталчилсан сурталчилгааг байрлуулсан. |

| | | |
|---|---|---|
| | | ➢ 2020 оны 2-р ээлжийн цэрэг татлага амжилттай болж дуусав. Биеийн бүтэц тодорхойлох аппаратаар 652 хүүхэд үзэж зөвлөгөө өглөө<br>➢ Нийслэлийн ЭМГ-ын нэрэмжит 5 төрөлт тэмцээнд баг бэлдэн оролцсон. |
| | | **Хороодын өрхийн эмнэлгүүдийн үйлчилгээний стандартыг шинэ түвшинд гаргаж, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэхэд анхаарч материаллаг бааз, хүний нөөцийн ур чадвар, боловсон хүчний орон тоо, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд**<br><br>➢ Эрүүл мэндийн яамнаас 2020 онд Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүүжилтийг 2 дахин нэмэгдүүлж, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хүний нөөц болон багаж тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг шат дараатай авч хэрэгжүүлсэн. Үүнд: 1,6, 20 дугаар хорооны ӨЭМТ-үүд Искра аппарат, 1, 6, 8, 18 дугаар хорооны ӨЭМТ-дэд Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, 4, 5, 6, 10 дугаар хорооны ӨЭМТ-дэд хүчил төрөгч өтгөрүүлэгч, 3, 4, 5, 8, 20, 17 дугаар хороодын ӨЭМТ-дэд УВЧ аппарат, 4, 5 дгаар хорооны ӨЭМТ-дэд Фото аппарат, тарианы шахуурга памп зэрэг тоног төхөөрөмжүүдийг олгосон. Мөн ӨЭМТ-ийн санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой ӨЭМТ-үүд 30 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийж, ширээ, сандал, компьютер зэргийг өөрсдийн төсвөөс авч тусламж үйлчилгээгээ сайжруулан ажиллаж байна.<br><br><u>ХУД-ийн ӨЭМТ-дэд 2020 онд ЭМЯ болон НЭМГ-аас доорх тоног төхөөрмжийг олгоод байна.</u><br><br>➢ УВЧ аппарат-6ш/ЭМЯ/<br>➢ ЭКГ аппарат-8ш /ЭМЯ/<br>➢ Судас тодруулагч-16ш /ЭМЯ/<br>➢ Зургийн аппарат-1ш<br>➢ ЭХО аппарат-16ш /ЭМЯ/ |

- Шээсний шинжилгээний аппарат-8ш /НЭМГ/



- Хан-уул дүүрэгт 5 хороо шинээр үүсэн салбар өрхийн эрүүл мэндийн төвүүд байгуулагдсантай холбоотойгоор Дүүргийн Засаг даргын Тамгын газраас тус хороодод 10 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж олгосон. Үүнд, Ургийн доплер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, УВЧ, биллиметр, Отсос зэрэг тоног төхөөрөмжүүдийг олгосон. 2020 онд Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд өмнөх онтой харьцуулахад их эмч 16, сувилагч 12, мэдээллийн ажилтан 6-аар нэмэгдсэн байна. Тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Энхтитэм, Аминтус, Амгалан Өрх, Мэндсаруул Өрх өрхийн эрүүл мэндийн төвүүд 5 салбар эмнэлгийг ажиллуулж байна.
- Шинэ коронавирусын /COVID-19/ халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн эрүүл мэндийг дэмжих хамгаалах, вирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 52 эмийн сантай хамтран дархлаажуулах, эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэхэд хамтран ажилласан. Эмийн сан, аж ахуйн нэгж байгууллагууд нь өөрсдийн нөөц бололцосны хүрээнд дархлаа дэмжих эмийн бэлдмэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис, хамгаалах хувцас хэрэгслээр дэмжлэг үзүүлэн нийт ***таван сая гаруй төгрөгийн*** үнэ бүхий зүйлээр дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан.

- ХУД-ийн 15 хорооны ӨЭМТ-д бүгд шилэн кабелаар "Жимобайл ХХК-аас өндөр хурдны интернэт авч ажиллаж байна. Интернетийн хурд - Жимобайл интернет-2GB
- ХУД-ийн ӨЭМТ-дэд нийт 408 сайн дурын идэвхитэн ажилладаг. Тус сайн дурын идэвхитэнүүд эрүүл мэндийн 16 сэдвээр сургалтанд хамрагдаж 22,500 иргэнд эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг хүргэсэн байна.
- 2020 оны 01 дүгээр сарын 14-ны өдөр Хан-Уул дүүргийн Яармаг бүсийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нийгмийн эрүүл мэндийн ажилтанууд Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг "Нийслэлийн мал эмнэлгийн газар"-тай хамтран "Анхны тусламж" сэдэвт эрүүл мэндийн боловсрол олгох сургалт болон хепатит B,C вирусын эрт илрүүлэг шинжилгээ болон нэг цэгийн үйлчилгээг 120 ажилчид, албан хаагчдад зохион байгуулж, шинжилгээнд хамрагдсан ажилчдад элэгний B,C вирусийн эрт илрүүлгийн ач холбогдол, элэгний хорт хавдрын талаархи зөвлөгөөг өгч, 2 төрлийн 200 ширхэг зөвлөмжийг тараан ажиллалаа
- 2020 оны 5 дугаар сарын 23-ны өдөр ХУД-ийн 21-р хорооны ажилтан, албан хаагчид, дүрс оношлогооны тэргүүлэх зэргийн эмчийг урьж үзлэг, шинжилгээг зохион байгуулж ажилсан.





ХУД-ийн 8 ӨЭМТ Чанарын хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан магадлан итгэмжлэлд хамрагдсан.

Эмч нараас магистр эмч-5 ажиллаж байна. Ахлах зэрэгтэй-15, Тэргүүлэх зэрэгтэй-8, Зөвлөх зэрэгтэй-2.

| | | |
|---|---|---|
| | | Сувилагч нараас ахлах зэрэгтэй-8, Тэргүлэх зэрэгтэй-2 сувилагч ажиллаж байна.<br><br>ӨЭМТ-дэд нийт 230 ажилтан ажиллаж байгаа ба үүнээс<br>• Дарга – 15<br>• Эмч – 86<br>• сувилагч – 68<br>• НЭМА – 15<br>• IT инженер – 3 /гэрээтээр/<br>• нягтлан бодогч – 5 /3 ӨЭМТ-ийн дунд 1/<br>• нярав - 5 /3 ӨЭМТ-ийн дунд 1/<br>• манаач, жолооч-17<br>• үйлчлэгч – 16 тус тус ажиллаж байна.<br><br>ӨЭМТ-ийн тусламж үйлчилгээг сайжруулах зохион байгуулалтын дараах багууд ажиллаж байна.<br>1. Удирдлагын баг буюу БГБХН<br>2. Чанарын баг<br>3. Халдвараас сэргийлэх хяналтын баг<br>4. Ёс зүйн баг<br>5. Өмч хамгаалах баг<br>6. Аюулгүй байдал, эрсдлийн баг<br>7. Сувилахуйн баг<br>8. Амилуулах суурь тусламжийн баг<br>9. Биеийн тамир, спортын баг ажилладаг.<br>Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаатай холбоотой холбогдох байгууллагуудаас ирсэн тушаал, шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| 2 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд | Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс хан-уул дүүргийн салбарт хариуцан хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс эрүүл мэндийн төвд дараах зориултууд хэрэгжиж байна. |

<table>
<tr>
<td></td>
<td>нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал.<br><br>Улсын төсөв, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажын гүйцэтгэл, чанар, үр дүн /</td>
<td>Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж хэрэгжүүлэн эх, нялхсын эндэгдлийг бууруулна.<br><br>➢ 2020 оны хүн ам 170110 үүнээс нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд 50206 /29.5%/, эмзэг болон эрсдэлтэй бүлгийн эмэгтэйчүүд 14770 буюу нийт нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 2.9%-ийг эзэлж байна.<br>➢ 2020 онд улсын төсвөөс жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн төсөв 117,951,464 сая төгрөг төсөвлөж ӨЭМТ-үүдийн дансанд шилжсэнээс 81,908,718 төгрөгөөр 261 ширхэг суулгац, 5640 ш тариа, дааврын хавсарсан эм 14326 ш, эрэгтэй бэлгэвч 31326 ш, яаралтай ууж сэргийлэх эм 258 ш, жирэмсний тест 659 ш, охидын ерөндөг 121 ширхэгийг тендэрээр Мари стофисоос авч ӨЭМТ-үүдэд ДХА, тест, бэлгэвч, яаралтай ууж хэрэглэх эмээр, дүүргийн нэг цэгийн үйлчилгээнд суулгац, ерөндөгөөр гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгсэлд хамруулан ажиллаж байна. Эмзэг бүлгийн 14770 НҮНЭ-ийн 41,6% буюу 6143 эмэгтэйд жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэлд хамруулсан.<br>2883 эмэгтэйд жирэмслэлтээс сэргийлэх тариа хийж, 12300 эмэгтэйд жирэмслэлтээс сэргийлэх эм олгож, эмэгтэйд жирэмслэлтээс сэргийлэх спираль 280 /ерөндөг/ тавьж,суулгац -250 эмэгтэйд, 247 эмэгтэйд жирэмслэлтээс сэргийлэх 72 цагийн яаралтай уух эм олгож, 25890 эмэгтэйд бэлгэвчийг үнэ төлбөргүй олгоод байна<br><br>➢ Улирал тутамд ӨЭМТ-үүдийн эмч нарт ЭМС-ын 2012 оны 63 тоот тушаал, 2019 оны 563 тоот тушаалаар сургалт зохион байгуулан эмч нарын мэдлэгийн нэмэгдүүлэн ажиллаж байна<br>➢ ХУД-ын 16-р хорооны Энхбуянт манал ӨЭМТ-ийн эмчтэй хамтран Гэр бүл төлөвлөлтийн орчин үеийн арга хэрэгслийн 13 нүүр бүхий товхимол бэлтгэн хэвлэн гэр бүл төлөвлөлтийн сурталчилгааны материалд ашиглаж байна.<br>➢ ӨЭМТ бүр, ХУЭМТ, ХУ яармаг салбарын хүлээлгийн хэсэгт жирэмслэлтээс сэргийлэх гэр бүл төлөвлөлтийн булан байршуулж, тараах материалаар иргэдийн хангаж байна.</td>
</tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | ➢ Эмзэг, эрсдэлтэй, эрхтэн тогтолцооны эмгэгтэй нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгсэлд хамрагдалт 82% байна.<br>➢ ӨЭМТ-үүд орчин үеийн гэр бүл төлөвлөлтийн сургалт, сурталчилгааг цахим, эмнэлгийн пэйж хуудас, брошур, хөдөлгөөнт самбаруудыг ашиглан 28678 хүнд сурталчилгаа хийсэн байна.<br>➢ Амин-тус ӨЭМТ Буянт-Ухаа цогцолбор сургуулийн ахлах бүлгийн сурагчдад<br><br>нөхөн үржихүйн эрүүл мэнд, БЗДХӨ, хүсээгүй жирэмслэлт ба түүнээс сэргийлэх, үр хөндөлийн хор уршиг, архи, тамхи хэрэглэхийн уршгийн талаарх сургалтыг сургуулийн эмч болон үе тэнгийн сурагчтай хамтран сургалтуудыг тогтмол явуулдаг. Үе тэнгийн сургагч багшаар 21 хүүхэд бэлтгэгдсэн.<br>➢ 2020 онд жирэмсний хяналтанд хянагдаж төрсөн 4891 эмэгтэйд тараах материал, үзүүлэн хуудас ашиглан гэр бүл төлөвлөлтийн мэдээлэл, төрсний дараа ӨЭМТ-үүдийн эмч, сувилагч нар гэрийн идэвхитэй эргэлтээр үзлэг хийх явцдаа мэдээлэл өгч ажилласан.<br><br>➢ 2020 оны жилийн эцсийн байдлаар үр хөндөлт 78 буюу 0,15 хувь байна. Гэр бүл төлөвлөлтийн орчин үеийн арга хэрэгслийн сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн гэр бүл төлөвлөлтөнд хамруулан ажиллах.<br>➢ Цахим хэлбэрээр<br>✓ Эрүүл удмын төлөө хамтдаа 649<br>✓ гэр бүл төлөвлөлт 9<br>✓ Нярайн хүүхдийг усанд оруулах зөвлөмж 332<br>✓ Нөхөн үржихүйн эрүүл мэндийн бусад асуудал (Үргүйдэл, Цэвэршилт) 4963<br>✓ хүүхдийн хооллолт ба амин дэм 38<br>✓ Эхийн сүүгээр хооллох ач тус, нэмэгдэл хоол өгөх зааварчилгаа 4986<br>✓ Жирэмсэн үеийн хооллолт 18\\<br>✓ маамуугаа хамгаалья 20<br>✓ Жирэмсний сургалт 100<br>✓ Нөхөн үржихүйн эрүүл мэнд эмч зөвлөж байна 2308<br>✓ Д амин дэмийн дутагдал 950<br>✓ Нөхөн үржихүйн зам болон бэлгийн замаар дамжих халдвар 1208 |

- ✓ Төмөр дутагдлын цус багадалт 950
- ✓ Төрөлтийн үе 1500
- ✓ Үргүйдэл цэвэршилт 1100
- ✓ эхийн сүүгээр хооллолт 950
- ✓ БЗХӨ сэргийлье 1100
- ✓ Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол 1100
- ✓ Нярай хүүхдийн асаргаа сувилгаа 53
- ✓ БЗДХ гэж юу вэ 368
- ✓ Жирэмсний үеийн сэтгэл гутрал 428
- ✓ Төрсний дараах сэтгэл гутрал гэж юу вэ 628
- ✓ Жирэмсэн үеийн дасгал хөдөлгөөн 423
- ✓ Агаарын бохирдол жирэмсэн эхчүүдэд үзүүлэх нөлөө гэх мэт 197 удаагийн давтамжтай сургалтыг цахим хэлбэрээр хийж нийт 101246 хүн хамрагдсан байна.

**2020 11 сарын байдлаар:**

**Дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/**

- ➢ 2020 онд **"Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил"**-ийн хүрээнд Хан-уул эрүүл мэндийн төв нь "Нэг цэгийн цогц тусламж үйлчилгээг "бий болгож, жирэмсэний хяналтыг сайжруулж , эх нярайн эндэгдэл бууруулж ажилласан.
- ➢ 2020 онд эмэгтэйчүүдийн кабинетийг тусад нь гаргаж, эх барих эмэгтэйчүүд их эмч болон бага эмчтэй ажиллуулснаар эмэгтэйчүүдийн өвчнийг эрт илрүүлэх, эмчлэн эрүүлжүүлэх, эрүүл мэнддээ анхаарах анхаарал ,тавих хандлага нэмэгдэж байна.
- ➢ ХУЭМТөв нь эх барихын зөвлөх эмч авч ажиллуулснаар эх ,нярайд тулгамдаж буй асуудал буурч ,ажлыг үзүүлэлт сайжирч буй харагдаж байна.
- ➢ Жирэмснээс хамгаалах аргуудын сонголт нэмэгдсэн ч, хэрэглэх боломж болон хэрэгцээнд нийцсэн хангалт дутмаг байна .

| | | |
|---|---|---|
| | | ➢ Эмчийн орон тоог нэмэгдүүлж ,Засгийн газраас олгох тэтгэмж нэмэгдэл олгодог болох , эмчийг тогтвор суушилтай ажиллах тал дээр анхаарч ажиллах.<br><br>➢ Эх барих, эмэгтэйчүүдийн эмчийг хүчин чадалтай эхогоор хангаж,дүүргийн хэмжээнд хяналтанд байгаа жирэмсэн эмэгтэй урагт хромосомын эмгэг, төрөлхийн хөгжлийг эмгэгийг оношлосноор эрхтэн тогтолцооны эмгэгтэй болон хромосомын эмгэгтэй хүүхэд төрөхөөс сэргийлж, гэр бүлийн эдийн засагт зэрэгээр нөлөөлнө.<br><br>➢ ӨЭМТ дээр эх барихын бага эмчийн орон тоог нэмж жирэмсний хяналтыг хийлгэж, чанарыг сайжруулах.<br><br>➢ Иргэдийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор бичиг баримтын зөрчил ихээр гарч байна.<br><br>➢ Жирэмсэн эхчүүдийн дундах эрүүл мэндийн боловсрол жирэмсэн үеийн тусламж үйлчилгээний талаархи мэдлэг сул байна. Тиймээс жирэмсэн эхчүүдийн сургалтыг тогтмол хийх,сургалтын өрөөг тусад нь гаргах.<br><br>➢ Жирэмсэн эхчүүдэд зориулсан цахим хуудас нээх болон гарын авлага тогтмол хийж өгөн мэдээллээр хангаж байна.<br><br>➢ Жирэмсний хяналтын эмч, ӨЭМТ-үүдтэй хамтран ажиллах. Цаашид дүүргийн эмнэлэгт жирэмсний эмгэгийн тасаг нээж ,төрөлтийг дүүргийн эмнэлэгтээ шийддэг байвал хүндрэл чирэгдэл ,бага байхаар байна.<br><br>➢ **Covid-19** цар тахлын халдварт өвчний үед УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС болон ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНААС гаргасан зөвлөмжийн дагуу ажиллаж, сургалтыг цахим хэлбэрээр хүргэж байна.<br><br>➢ Цаашид эх барихын эмчийн орон тоог нэмэгдүүлэх нь нэн чухал зорилт болж байна.<br><br>1. Жирэмсний эрт үеийн хяналт 4762 буюу 89,1% |

| | | |
|---|---|---|
| | | 2. 2020 оны эхний 11 сарын байдлаар нялхасын эндэгдлийн 22 тохиолдол , амьгүй төрөлтийн 19 тохиолдол бүртгэгдсэн.<br>3. Эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүдийг ЖСА-д идэвхитэй хамруулснаар үүсч болох эрсдэл, хүндрэлээс сэргийлж чадсан. ЖСА хэрэглээ эмзэг, эрсдэлтэй бүлэг, эрхтэн тогтолцооны эмгэгтэй эмэгтэйчүүдийн 82%, ЖСА 81% хамрагдсан байна.<br>4. Эрсдэлт бүлгийн иргэд болон жирэмсэн эхчүүдийг ДОХ/Тэмбүүгийн сорилд хамруулснаар БЗДХӨ-с сэргийлэх, төрөлхийн тэмбүүтэй хүүхэд төрөхөөс сэргийлж байна.<br>5. Зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг хөхний үзлэг, умайн хүзүүний пап шинжилгээнд хамруулснаар хорт хавдар болон түүний хүндрэлээс урьдчилан сэргийлж, тухайн өвчний талаарх иргэдийн мэдлэг дээшилсэн.<br>Хамралтын хувь: 20120 оны эхний 11 сарын байдлаар<br>✓ Умайн хүзүүний хорт хавдар илрүүлэх үзлэг 3728 буюу 38%<br>✓ Хөхний хорт хавдар илрүүлэх үзлэг 33443 буюу 78% байна.<br>6. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд болон өсвөр үеийхэнд эрүүл мэндийн боловсрол олгосноор үүсэж болох эрсдэлийн түвшин бууруулж болохуйц мэдлэг мэдээлэлтэй болсон.<br>7. ХӨЦМ-ийг хэрэгжүүлж ажилласнаар 0-5 хүртэлх насны хүүхдийн дунд амьсгалын замын өвчний хүндрэл буюу эндэгдэл гараагүй.<br>8. Ажлын байран дээрээ сургалт явуулж баг хамт олноороо зөвлөлдөн шийдвэр гарган ажиллах нь илүү үр дүнтэй байна.<br>9. Нарийн мэргэжлийн эмч нарт хянагдаж байгаа жирэмсэн эхчүүдийн хяналтыг чанаржуулж, өртөмтгий бүлгийн жирэмсэнг онцгой хяналтанд, зөвлөх эмч болон бусад нарийн мэргэжлийн эмч нартай хамтран хянах шаардлагатай гэсэн дүгнэлийг хийлээ.<br><br>Covid-19 цар тахлын халдварт өвчний үед УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС болон ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНААС гаргасан зөвлөмжийн дагуу ажиллаж, сургалтыг цахим хэлбэрээр хүргэж байна.Цахимаар 101246 иргэдэд 118 сэдвээр ЭМБО мэдээллийг хүргэсэн.<br><br>“Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургуулийн болон сургуулийн өмнөх насныхны дунд зонхилон тохиолдох шүд цоорох өвчлөлийг эрт |

| | | |
|---|---|---|
| | | илрүүлж, цаашдын хүндрэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, өвчтэй илэрсэн хүүхдүүдийг эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авах, хүүхэд, багш,эцэг эхчүүдэд сургалт явуулж, амны хөндийн эрүүл мэндийн тухай мэдлэг, амны хөндийг зөв арчлах дадлага олгох замаар шүд цоорох өвчний тархалт, эрчмийг бууруулах.Үүний дагуу дараахь зорилтуудыг тавин ажилласан.<br><br>2020 онд нийт 21762 хүнд амны хөндийн эрүүл мэндийн үзлэг хийж, өвчний улмаас 15759 хүн үзүүлснээс анхдагчаар 12652 хүнд амны хөндийн эрүүл мэндийн тусламж үзүүлж, 5440 хүн буюу 43%-г эрүүлжүүлэн ажиллаа. Нийт үзлэгийн буюу 50%-г хүүхдийн үзлэг эзэлж байна.Энэ жил хүүхдийн үзлэгийн эзлэх хувь урд оноос даруй 25%-р өссөн байна. Анхдагчаар 4095 хүүхэд үйлчлүүлснээс 2129 буюу 52% нь эрүүлжүүлсэн байна. Энэ нь урд оноос 2.1%-р өссөн үзүүлэлттэй байна.<br>Корона вирусын халдварын нөхцөл байдалтай холбогдуулан авч буй арга хэмжээний хүрээнд Улсын онцгой комисоос 2019 оны12 сараас 2020 оны 06 сарын 30-ны өдрийг хүртэл хөл хорио тогтоох шийдвэр гаргасантай холбогдож сургууль цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа хаагдсантай холбоотой хүүхдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа түр зогссон байна.<br>Сургууль цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.<br>Корона вирусын халдварын нөхцөл байдалтай холбогдуулан авч буй арга хэмжээний хүрээнд Улсын онцгой комисоос 2019 оны12 сараас 2020 оны 06 сарын 30-ны өдрийг хүртэл хөл хорио тогтоох шийдвэр гаргасантай холбогдож сургууль цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа хаагдсантай холбоотой хүүхдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа түр зогссон байна.<br>ХУДЭМТ-ийн шүдний кабинетаар нийт урьдчилан сэргийлэх үзлэгээс 726 хүүхэд үзлэгт хамрагдаж 43,56 % нь эрүүлжсэн байна<br>Нийт үзлэгийн буюу 50%-г хүүхдийн үзлэг эзэлж байна.Энэ жил хүүхдийн үзлэгийн эзлэх хувь урд оноос даруй 25%-р өссөн байна. Анхдагчаар 4095 хүүхэд үйлчлүүлснээс 2129 буюу 52% нь эрүүлжүүлсэн байна. Энэ нь урд оноос 2.1%-р өссөн үзүүлэлттэй байна. Нийт урьдчилан сэргийлэх үзлэгээс 121хүүхэд буюу 7.26% нь эрүүлжсэн байна. Мөн шүдний |

| | | |
|---|---|---|
| | | кабинетэд ирж эмчилгээ хийлгэж байгаа 121 хүүхдэд видео болон биечлэн муляж дээрх сургалтыг хийлээ<br><br>ХУД- ийн харъяа цэргийн насны залуучуудын амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгээр нийт 4782 хүн хамрагдсанаас 1645 буюу 32% нь амны хөндийн өвчлөлтэй илэрсэн байна. Энэ үзүүлэлт нь урд онтой харьцуулбал 1%-р буурсан байна. 2020 онд үзлэгт хамрагдан өвчтэй илэрсэн залуучуудаас 30 хүн буюу 1,9% нь бүрэн эрүүлжиж, энэ нь урд оноос 0,4%-р өссөн байна.<br><br>"Дэлхийн амны хөндийн эрүүл мэндийн өдөр"-ийг тохиолдуулж Яармаг салбарын шүдний кабинетын эмч , сувилагч нар эмч ажилчдын " Амны хөндийн эрүүл мэндийн" урьдчилан сэргийлэх үзлэг,сургалт хийж, шүдний өнгөрийг тодорхойлон, дархлаа дэмжих витамин болон шүдний сойз өглөө.<br><br>ХУД-ийн эрүүл мэндийн төвийн шүдний ХУЭМТөвийн 200 гаруй ажилчдад Wellglobin B12 витаминыг дархлааг дэмжих зорилгоор тараасан.<br><br>ХУД-ийн эрүүл мэндийн төвийн шүдний кабинетаас 2020 оны 02 сарын 21-нд “ИХ ТӨГӨЛ ХХК” эм ханган нийлүүлэх байгууллагатай хамтран “Маскаа дамалдаг биш Хуваалцдаг байя”, “Хайр хуваалцахаас эхэлнэ”уриан доор өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж байгаа тус төвийнхөө гардан ажиллагаатай кабинетуудын эмч,сувилагч, үйлчлэгч, хөтөч, цахимын ажилтангуудад солонгос улсад үйлдвэрлэсэн нэг удаагийн амны хаалтны багцыг “С” амин дэмийн хамт тараасан.<br><br>➢ Насанд шүд цоорлын тархалт **85%,** эрчим **7** байна. Энэ нь урд оноос тархалт 1,4%-р багассан, эрчим 1 промилээр ихэссэн үзүүлэлттэй байна. 2017 оны улсын дундажаас тархалт 1,1%-р багасч, эрчим 1 промилээр ихэссэн байна.<br>➢ 12 насанд насанд шүд цоорлын тархалт **80%,** эрчим **5,8** байна.Энэ нь урд оноос тархалт 0,3%,эрчим 0,1 промилээр багассан байна. 2017 оны улсын дундажаас тархалт 0,3 %-р их, эрчим 0,4 промилээр бага байна.<br>➢ Үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс 947 буюу **12,8%** нь одоогоор эрүүлжсэн байна. Энэ нь урд онтой харьцуулбал 0,2%-р ихэссэн байна. |

| | | |
|---|---|---|
| | | ➢ ХУД-ийн харъяа хүн амын амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлтийн ажлын энэ оны төлөвлөгөө цар тахалын улмаас түр зогссон<br><br>Цахимаараар нийт **34** удаагийн сурталчилгаа мэдээлэл хийж нийт давталттай тоогоор **46972** хүнд мэдээлэл хүрсэн. |
| 3 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг тухайн онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал. Нийслэлийн төсөв, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, чанар, үр дүн | **Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр боловсруулж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, салбар дундын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ. Зорилтын хүрээнд:**<br><br>ТТТӨ-ний идэвхижил, дэгдэлтийн үед ажиллах хүний нөөцийн судалгааг гаргаж бэлтгэл ажлыг ханган дараах арга хэмжээнүүдийг авч ажиллаа. Томуу томуу төст өвчний дэгдэлтийн үед уртасгасан цагаар ажиллах эмч нарыг ажиллуулж Иргэдэд зөвлөгөө өгөх 11345903 тоот утсыг хүүхдийн эмч, ахмадын эмч, хүүхдийн ерөнхий зохицуулагч нарын өрөөнд байршуулан зөвлөгөө өгсөн. Мөн яаралтай эм тарианы бикс болон бусад багаж тоноглолыг хүүхдийн өрөө, хүлээн авах яаралтай тусламжийн хэсэгт байршуулсан ЭМС-ын А/07 тоот тушаал, ЭМС-ын 08 тоот албан даалгавар НЭМГ-ийн даргын "Эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах тухай" А/02 тоот тушаалын дагуу ЭМТ-ийн даргын А/04, А/13 тоот тушаалуудыг гарган ТТТӨ-ний үед авах арга хэмжээг эрчимжүүлэн ажилласан.<br><br>Дүүргийн засаг даргын тамгын газрын дэргэдэх /Томуу томуу төст өвчинтэй тэмцэх сэргийлэх ажлын хэсэг / Дүүргийн нийгмийн хөгжлийн хэлтэсийн дарга , боловсролын хэлтэсийн дарга, ЭМТ,НЭ-ийн дарга, ӨЭМТ –үүдийн эмч нар хуралдаж хүүхдийн байгууллагад ирцийн тандалт, дэмжлэгт хяналт хийх, масктай Хан-уул дүүрэг аяныг зохион байгуулах, ТТТӨ-ний дэгдэлтийн үед шаардалагатай зүйлсийн нөөцийг бүрдүүлэхэд Дүүргээс санхүүжилт гаргах, НЭ, ӨЭМТ, ЭМТ мэдээллээ солилцон хамтран ажиллах талаар тус тус хэлэлцэн санал бодлоо солилцсон.<br><br>Дүүргийн эрүүл мэндийн төвөөс дэмжлэгт баг гарган томуугийн дархлаажуулалт явагдаж байгаа түр цэгүүд болон байнгын цэгүүдэд дэмжлэгт хяналт хийн ажиллаж байна.т Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг хүсэн Хан-Уул |

| | | |
|---|---|---|
| | | дүүргийн засаг даргын тамгын газарт хүсэлт гаргасны дагуу 10 нэр төрлийн хэрэглэгдэх материалаар ӨЭМТ-үүд, ХУНЭ, ХУЭМТ- үүдийг дэмжин ажилласан.<br><br>Томуу томуу төст өвчний үед 12-р сараас эхлэн 4 сарын 1-ыг дуустал ажлын өдөр 17-19, ням гаригт 10-16 цагийн хооронд жижиүүр эмч сувилагч нар илүү цагаар жижүүрлэн ажилласан.<br><br>Шинэ коронавирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, дэгдэлтийн үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний аюулгүй байдлыг хангах, сэргийлэх үүднээс НЭМГ-ийн даргын 2020 оны 01 сарын 31-ны өдрийн 01 тоот албан даалгаварын дагуу ӨЭМТ-ийн нийт үзлэгийн 60%-аас доогщшгүй гэрийн эргэлтэнд шилжүүлэн, гэрийн эргэлтийг сайжруулах зорилгоор төлөвлөгөө болон гэрээр эргэлт хийх хувиарь боловсруулан гэрийн эргэлтийг эрчимжүүлэн нярай хүүхдэд, ахмад настан, суурь өвчтөй хэвтрийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тогтмол гэрээр эргэлт хийж ажилласан.<br><br>Хогоо Ангилах Хөдөлгөөний хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба The Asia Foundation Mongolia хамтран иргэдэд хог хаягдлын мэдлэг олгох, хог хаягдлаа ангилан ялгах, бууруулах дадал хэвшлийг олгох, эко клубуудыг дэмжих, харилцаа холбоог нэмэгдүүлэх зорилгоор хороотой хамтран Хогоо сайн ангилдаг орон сууц хотхон хорооллын нөхцөл байдалтай танилцаж туршлага судлан хорооныхоо бусад хогын цэгүүдэд хяналт тавьж, хогыг ачуулан, хог ангилан ялгах цэг байгуулан агаар орчны эрүүл мэндийг сайжруулан ажиллалаа.<br><br>Халдварт өвчний голомт гарсан газар очиж эрүүл мэндийн зөвөлгөө болон урьдчилан сэргийлэх үзлэг хийж сэжигтэй тохиолдол илэрвэл ХӨСҮТ-рүү яаралтай явуулж томуу, томуу төст өвчний мэдээг 7 хоног бүр мэдээллэн ажиллаж байна.<br><br>Ковид-19 өвчний үеийн мэдээ мэдээлэл болон тусгаарлалтаас гарсан иргэдийг өдөрт 2 удаа өрхийн эмч хянаж мэдээ мэдээллийг цаг тухайд нь явуулж ажиллаж байна.<br><br>ӨЭМТ-үүд Тусгаарлах өрөөний хамгаалах хувцас, хэрэгсэл нөөцлөн ажиллаж байна |

| | | |
|---|---|---|
| | | Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч ажилчид 2020 оны 03 сарын 06- ны өдөр нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл зөв өмсөж тайлах дадлага хийлээ. Байгууллагын дотоод орчинд /хаалганы бариул болон өрөө тасалгаа, тоног төхөөрөмж /халдваргүйжүүлэлт DETER" ANIOS-ийн бодисоор цэвэрлэгээг 2 цаг тутамд хийж байна.<br><br>ӨЭМТ-үүд нь COVID-19 халдварын үед 1-2 метрийн зайд халдвар дамжих эрсдэлтэй тул ӨЭМТ-р үйлчлүүлж байгаа иргэдээ халдвараас сэргийлж зай барь гэсэн тэмдэглэгээг хэрэгжүүлж байршуулсан.<br><br>Агаар дусал, амьсгалын замаар халдварладаг Шинэ коронавирус буюу Ковид-19, "Томуу, томуу төст өвчин, салхин цэцэг, улаанууд, улаанбурхан, гахайн хавдар, менингококк, гепатит А, өвчний талаар иргэдэд фэйсбүүк, цахим хаягаар иргэдэд өдөр тутам сургалт хийж зөвлөгөө өгч гарын авлага сургалтын материал тогтмол тараан ажиллаж байна.<br><br>Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас жил бүр зохион байгуулдаг Дэлхийн тамхигүй өдрийг 2020 оны 5 сарын 31нд "Тамхигүй хамт олон" харьяа хороодын айл, ажилчид болон мэдээллийн самбарт тамхины хор уршгийн талаар сурталчилгааны хуудсыг байршууллаа.<br><br>Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн бэлтгэсэн "Угаарын хийн хордлогоос сэргийлье" видео, шторк, сурталчилгааг Хан-Уул дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүд цахим хуудсанд 2020 оны 11 сарын 23-ны өдөр байршуулж иргэдэд цахим эрүүл мэндийн боловсрол олгосон. Тус видео, шторк, сурталчилгаанд нийт-48 хүн хандалт хийсэн байна.<br><br>Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн бэлтгэсэн "Гараа тогтмол сайтар савандаж угаацгаая" видео, шторк, сурталчилгааг өрхийн эрүүл мэндийн төвийн цахим хуудсанд байршуулж иргэдэд цахим эрүүл мэндийн боловсрол олгосон. Тус видео, шторк, сурталчилгаанд нийт-26843 хүн хандалт хийсэн байна.<br><br>Мэндсаруул ӨЭМТ нь Нийслэлийн Засагдаргын 2019 оны 09 дүгээрсарын 10-ны өдрийн "Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай" А/920 дугаар захирамж, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/318 дугаар захирамжийг үндэслэн хорооны Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 13-ны |

| | | |
|---|---|---|
| | | өдрийн №189 тоот албан бичгийн хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 30 аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүллээ. "Их цэвэрлэгээ 90" минут арга хэмжээнд хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 30 аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан албан хаагч, 42 гаруй иргэн хамрагдаж 4220 м2 талбайг цэвэрлэж 2,3тн хогийн устгасан. Мөн 30аж ахуйн нэгж, байгууллага 13 ширхэ гсандал, 31 ширхэг хогийн сав, 2140 м хайс хашлага, 33 хаяг, хаягийн байгууламжийг угааж цэвэрлэсэн.<br><br>Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй болгон боловсруулах байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент”-ийн чиглэлээр хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх чиглэлээр эмнэлгийн ажилчдад сургалт хийсэн.<br><br>Хан-Уул эрүүл мэндийн төв, Цэц-До өрхийн эрүүл мэндийн төв Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах заавар”-ын дагуу Эмнэлгийн багаж, хэрэгсэл ариутгах гэрээг 2020 оны 04 сарын 01-ны өдрөөс 2020 оны 07 сарын 01-ны өдрийн хүртэлх 3 сарын хугацаатай гэрээ байгуулан багаж, төхөөрөмжийг ариутгаж байна. Гэрээний дагуу төлбөр 60000 /жаран мянган төгрөг/ эрүүл мэндийн төвд тушаасан.<br><br>“Элемент Медикал” ХХК-тай 2020 оны 01 сарын 01-ны өдрөөс 2020 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэл 1 жилийн гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрийн дагуу Эрүүл мэндийн сайдын 459 тоот тушаалын аргачлалаар тооцож сар 50000 /тавин мянган төгрөг/-ийг гэрээнд заасан дансанд шилжүүлж байна.<br><br>Халдварын өндөр эрсдэлтэй хог хаягдлыг улаан уутанд төвлөрүүлэн 7 хоног бүр эмнэлгийн болон халдварын өндөр эрсдэлтэй хогоо ачуулж үйл ажиллагаа тогтмолжсон.<br><br>Сар бүр “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын тайланг гаргаж ХУЭМТ-д өгч байна. Өдөр бүр эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг бүртгэж, долоо хоногийн лхагва гариг бүр Элемент , ХК-д байгууллагад хог хаягдлыг хүлээлгэн өгч хөтлөгдөх маягтыг бүрэн хөтөлж байна. |

| | | |
|---|---|---|
| | | ӨЭМТ-үүдийн ажилчдад Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ангилал,хогийн уут, саванд тавигдах шаардлага,эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, зөөвөрлөх, түр байршуулах, тээвэрлэх үйл ажиллагаа ,эмнэлгийн хог хаягдлыг түр хадгалах байранд тавигдах шаардлага,хог хаягдлыг устгал талаар сургалт хийсэн.<br><br>ӨЭМТ-үүд эмч эмнэлгийн ажилчдад улирал бүр тогтмол Эмнэлгийн хог хаягдлын менежмент, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын мэдээлэл цуглуулах талаар сургалтанд зохион байгуулдаг<br><br>**Ололттой тал:**<br><br>• Эрүүл мэндийг дэмжих сангаас сургалт сурталчилгаанд зориулж санхүүжилт олгосноор иргэдийн дунд хийх сургалт сурталчилгааны төрөл , тоо хэмжээ нэмэгдэж үйл ажиллагаа сайжирсан.<br>• Агаарын бохирдол болон амьсгалын замын өвчлөлөөс сэргийлэх талаар сурталчилгааны материалуудыг хэвлэн тараасан<br>• Орчны эрүүл мэндийн талаархи иргэдийн мэдлэг хандлага сайжирсан.<br><br>**Дутагдалтай тал :**<br><br>Агаарын бохирдол болон хөрсний бохирдол хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа нөлөөллийн талаар хийсэн үр дүнтэй судалгаа хийгдээгүй<br><br>Ахуйн хог хаягдлаа гудамж талбайд байршуулсан хог хаягдлын савнуудад хүн бүр хийж хэвшихгүй ил задгай гудамж талбайд хаяж байгаа<br><br>Санхүүжилт багатайгаас үүдэн урьдчилан сэргийлэх үзлэг, өдөрлөг, сургалт сурталчилгаа зохион байгууулахад хүндрэлтэй байна.<br><br>**Анхаарах асуудлууд:** Хог хаягдлаа зөв ангилан савлаж хаядаг хэвшилд иргэдийг сургах |

| | | |
|---|---|---|
| 4 | Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийсэн ажлын гүйцэтгэл, чанар, үр дүн | **Иргэдийг чихрийн шижин, цусны даралт ихсэх, хорт хавдар зэрэг зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт жилд нэг удаа үнэ төлбөргүй хамруулах, өвчнийг хянах цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.**<br><br>Халдварт бус өвчний эрсдэл болон хүндрэлээс урьдчилан сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол зорилгоор ЭМТ, ӨЭМТөвүүд 2020 онд нийт 1566 удаагийн цахим сургалт, сурталчилгаа мэдээллийг хийсэн.<br>Жилийн эцсийн байдлаар Артерийн даралт, чихрийн шижний эрт илрүүлэгийн үзлэгт 18-аас дээш насны нийт 112,849 хүнийг хамруулахаас 60.2%-ийг буюу 67982 хүнийг хамруулсан. Үүнээс давтан үзлэгт 10282 хүн хамрагдаж батлагдсан артерийн даралт 166 байна. Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг зорилтот бүлгийн 10096 хүн хамруулахаас 37%-ийг буюу 3728 хүнийг хамруулсан. Хөхний хавдрын эрт илрүүлэг үзлэгт зорилтот бүлгийн 43257 хүн хамрагдахаас 78%-ийг буюу 33743 хүнийг хамруулсан.<br><br>Чихрийн шижин хэв шинжийн 2 эрт илрүүлэг үзлэгт нийт 59330 хүн хамрагдсанааас 24778 эрэгтэй, 34552 эмэгтэй хүн хамрагдаж батлагдсан чихрийн шижин 12 байна.<br><br>**"Эрүүл залуус" аян хэрэгжүүлж, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгон, эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулна.**<br><br>Дэлхийд 7 тэрбум хүний 3 тэрбум хүн social platform-ыг маш идэвхитэй хэрэглэж байна. 60 секундэд Фэйсфүүкэд 1 сая хүн идэвхитэй байж, 2 тэр бум хүн бизнес эрхэлж байна. Монгол улсын нийт 3 сая хүний 2 сая хүн нь Фэйсфүүкийг маш идэвхтэй хэрэглэдэг бөгөөд 79,25% өдөр бүр идэвхитэй хандалттай байдаг байна. Иймд орчин үеийн нийгмийн хөгжлийг даган интернет орчинд мэдээлэл сургалт сурталчилгааг хийж залуучуудын эрүүл мэндийн боловсролыг олгохоор ажиллаж байна. 20 ӨЭМТөвтэй хамтран нийт 21 хөтөлбөрийн хүрээнд 100 сургалтын сэдэв боловсруулан цахим сүлжээнд байршуулан мэдээлэл зөвлөгөөгөөр хангаж ажиллаж байна. ЭМТ, ӨЭМТөвүүд 2020 оны 11 сарын байдлаар 1566 удаагын цахим сургалт мэдээллийг хийсэн. |

| № | Хөтөлбөрийн нэр | Хийсэн сургалтын тоо |
|---|---|---|
| 1 | Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр | 43 |
| 2 | Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр | 88 |
| 3 | Гэртээ харих зам нийслэлийн хөтөлбөр | 12 |
| 4 | Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги | 55 |
| 5 | Зорилтот бүлгийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр | 8 |
| 6 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр | 42 |
| 7 | Нийслэлийн эрүүл мэнд дэд хөтөлбөр | 38 |
| 8 | Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр | 42 |
| 9 | Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр | 68 |
| 10 | Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр | 114 |
| 11 | Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр | 586 |
| 12 | Хотжилт ба эрүүл мэнд үндэсний хөтөлбөр | 20 |
| 13 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр | 5 |
| 14 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөр | 6 |
| 15 | Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр | 50 |
| 16 | Хүүхдийн насны онцлогт тохирсон хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр | 42 |
| 17 | Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөр | 39 |
| 18 | Эрүүл насжилт, настны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр | 72 |
| 19 | Эрүүл шүд – Эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөр | 39 |
| 20 | Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр | 197 |
| | **Нийт хийсэн сургалт сурталчилгаа** | **1566** |

| Хоёр: Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн | | |
|---|---|---|
| 1 | Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт буюу байгууллагын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /КР1/-ээр үнэлсэн үнэлгээний дүн | Хан-Уул эрүүл мэндийн төвийн хүний нөөцийг 2020 онд хөгжүүлэх төлөвлөгөө гарган 2020 оны эхний 11 сарын байдлаар хоол, унааны хөнгөлөлт нийт ажилтанд 223,402,300 төг олгосон байна.<br><br>Нийт ажилчдын ажилласан жилийг тулган, шинэчилж Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 382, 472 тоот тогтоолын дагуу төвийн даргын 2020 оны 01 сарын 02-ны өдрийн Б01 тоот тушаалаар эмч ажилтнуудын цалингийн шатлал, цалингийн хэмжээг батлан хэрэгжүүлж байна. Нийт 45 ажилтны цалингын шатлалыг ахиулж, төрийн албанд ажилласан хугацааны цалингийн нэмэгдэлийг 160 ажилтанд олгож нийт ажилтны цалинг 8% нэмэгдүүлсэн.<br><br>Байгууллагын дотоод журам, үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан хамтын гэрээний заалтын дагуу буцалтгүй тэтгэмжид 31 эмч ажилчид хамрагдсан байна<br><br>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 395 дугаар тогтоол, Хан-Уул эрүүл мэндийн төвийн удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн эрүүл мэндийн төвийн даргын 2020-04-01-ний өдрийн А29 тоот "Эмч эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудад үр дүнгийн урамшуулал олгох журам батлах тухай "тушаалыг батлан хэргжүүлж байна. 2020 оны эхний 3-р улирлын байдлаар 211 ажилтанд үр дүнгийн урамшуулалаар 281,847,600 төгрөг олгосон байна.<br>2020 оны 04 сарын 17-ны А/36 тоот тушаалаар Нийтлэг үйлчилгээний ажилчдын баярыг тохиолдуулан үйлчилгээний албан хаагчдад 1.080.000 төгрөгний дулаан хувцас хэрэгсэл авч хангалаа.<br>2020 оны 05 сарын 20-ны А/47 тоот тушаалаар Сувилахуйн баярыг тохиолдуулан сувилагч нөрт хөдөммөрийн нөхцөл, аюулгүй байдалыг хангах зорилгоор 3.553.000 төгрөгний хувцас хэрэгсэл авч хангалаа.<br>ТТТӨ дэгдэлт, Ковид 19 цар тахлын үед ХУЭМТ-ийн Даргын 2020 оны 03 сарын 02-ны А/23 тоот тушаалаар 12 хүртлэх бага насны хүүхдүүдтэй албан хаагчдын ажлын цагийг 1 цагаах богиносгон эцэг, хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллаа. |

| | | |
|---|---|---|
| | | 2020 оны 05 сарын 28-ны А/48 тоот тушаалаар Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан 162 эмч ажилчдын хүүхдэд хичээлийн хэрэгсэлээр хангаж ажиллаа.<br>Мөн Алтан гадас одонгоор шагнуулахаар 7, Хөдөлмөрийн хүндэт медаль-1<br>Ард түмний гавьяат-1<br>Ардын эмч-1<br>Салбарын жуух-4<br>Эм үйлдвэрлэл, хангамжийн тэргүүний ажилтан-1<br>Нийслэл, дүүргийн бусад шагнал – 11<br>Ажилтныг тодорхойлсон байна.<br><br>Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу коронавируст /COVID-19/ халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, цар тахалтай тэмцэх хүч хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх, удирдлагыг нягтруулах, онцгой нөхцөл байдлын үеийн хариу арга хэмжээний тактикийг боловсронгуй болгох, нэрвэгсдийг эмчлэх, хорио цээр, халдвар хамгаалал, хариу арга хэмжээ авах зорилго бүхий дадлага сургуулилтад 2020 оны 05 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд оролцлоо.<br><br><br>Дадлага сургуулийн хүрээнд Буянт-Ухаа спорт цогцолборт 300 ортой /Яармаг 300/ эмнэлэг.<br><br>Буянт-Ухаа спортын ордны 7790 м2 талбайд дэлгэсэн "ЯАРМАГ-300" эмнэлэг нь "Ковид-19" хөнгөн, дунд зэргтэй **300** өвчтөнийг хүлээж авч, эмчлэх хүчин чадалтай.<br><br>Эмнэлгийн хоёрдугаар давхрыг нөөцөнд авч, өвчлөл хүндэрсэн тохиолдолд **100-200** ор нэмж дэлгэх боломжтой юм.<br><br>Нэг ээлжинд **54** хүн, нийт **148** эмч, эмнэлгийн мэргэжилтэн **3** ээлжээр үүрэг гүйцэтгэв. |



Хан-Уул дүүрэгт байрлах Эх хүүхдийн нэгдсэн эмнэлэгт 100 ортой /Яармаг 100/ эмнэлэг. Нийслэлийн эх хүүхдийн нэгдсэн эмнэлгийн 2800 м2 талбайд дэлгэсэн "Яармаг-100" эмнэлэг нь хүнд болон маш хүнд өвчтөнийг хүлээж авч, эрчимт эмчилгээний тасагт хэвтүүлэн эмчлэх зориулалттай. Шаардлагатай тохиолдолд 500-1000 хүртэл ор дэлгэж, тусламж үйлчилгээ үзүүлэх боломжтой бөгөөд өдгөө **100** ор дэлгэснээс **10** нь маш хүнд өвчтөнийг хүлээж авах зориулалтаар иж бүрэн тоноглогдсон. Нэг ээлжинд **90** хүн, нийт **270** эмч, эмнэлгийн мэргэжилтэн **3** ээлжээр ажиллалаа.



ОБЕГ-ын харьяа Давтан сургалт, сэргээн заслын төв – 113 дугаар ангийг түшиглэн хээрийн эмнэлэг дэлгэсэн. Хээрийн энэхүү эмнэлэг нь аливаа өвчин эмгэгийн үед **50** хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх боломжтой, мэс засал, эрчимт эмчилгээ, дүрс оношилгооны хэсгүүдээс бүрдсэн, ханын хүчилтөрөгчийн хангамж, ариутгал халдваргүйтгэлийн хэсэг, агааржуулалтын систем, цэвэр бохир усны хангамжийг бүрэн шийдвэрлэсэн. Сургуулийн үеэр эмнэлэгт **30** гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажилласан.



"Ковид-19 цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ" сэдэвт гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтын **300 ортой** эмнэлгийн

**1-рт "ШАР БҮС",**

**2-рт "СУВИЛАГЧИЙН 3-р ПОСТ"-ыг**

тохижуулж шаардлагатай тоног төхөөрөмжийг байршуулж, хүний нөөцийг ханган ажиллаж байна.

Сувилагчийн пост- дээр нийслэлийн 4 дүүрэг хариуцан ажилласан бөгөөд ХУДЭМТ нь сувилахуйн пост-3-ийг хариуцан ажилласан. Сувилагчийн постонд 52 нэр төрлийн эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж бэлтгэн оролцлоо.






Яармаг 300 ортой эмнэлгийн шар бүс буюу завсрын бүсийг 3 хэсэгтэйгээр зохион байгуулан ажиллалаа. Үүнд:

- Хэвтэн эмчлүүлж, эдгэрээд эмнэлгээс гарч байгаа үйлчлүүлэгчийн хувцас хэрэгслийг халдваргүйжүүлэн гаргах хэсэг
- Эмч эмнэлгийн ажилчид хамгаалах хувцас хэрэгслээ тайлах, халдваргүйжүүлэх хэсэг
- Халдваргүйжүүлэх бодис материал хэрэгслийн нөөцийн буюу халдваргүйжүүлэх уусмал бэлтгэх хэсэг.




- Шар бүс дээр халдвар судлагч, ариутгагч, үйлчлэгч нийт 5 хүн ажил үүрэг гүйцэтгэн ажилласан.Шар бүсийн тохижилт үйл ажиллагаанд нийт 6 нэр төрлийн багаж

хэрэгсэл, 3 нэр төрлийн халдваргүйжүүлэх бодис, 8 нэр төрлийн хамгаалах хувцас хэрэгсэл, 5 төрлийн анос, зурагт хуудас, хаягийг хийж тус үйл ажиллагаанд





байгууллагаас нийт 1,677,810 төгрөгийг зарцуулсан байна.

Хан-Уул эрүүл мэндийн төв "КОВИД-19" дадлага сургуулийн Яармаг 100 эмнэлгийн Дүрс оношлогооны хэсгийг хариуцаж ажиллав.

- Зөөврийн рентген – 1
- Дүрс оношлогооны их эмч – 1
- Рентген техникч – 1

ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБА



Монгол Улсын Шадар Сайдын 2020 оны 04 дүгээр сарын 2 ... л, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 04 ду ... 47 тоот тушаалын дагуу “Ковид-19 цар тахлын үеийн харилцан ... э” сэдэвт гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулий ... үл мэндийн төвөөс эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, үйл ... йт 36 хүний бүрэлдэхүүнтэй баг томилон, шаардлагатай тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг бүрэн ханган оролцсон байна.

Хан-Уул эрүүл мэндийн алба "Ковид-19 халдварт цар тахлын үеийн хариу арга хэмжээ" дадлага сургуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, амжилттай оролцлоо.





- Хан-Уул эрүүл мэндийн албаны төв штаб – өгөгдсөн 6 цагийн байдал дээр ажиллаж **дүүргийн болон нийслэлийн эрүүл мэндийн газрын штабыг мэдээллээр** хангаж ажилласан.
- Яармаг 300 эмнэлгийн сургуулийн үеийн удирдлага, зохион байгуулалт
- Яармаг 300 эмнэлгийн бэлтгэл, ар тал
- Яармаг зоо эмнэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Яармаг 100 эмнэлгийн дүрс оношлогооны хэсэг

2020 оны 2-р ээлжийн цэрэг татлагын үйл ажиллагаанд нарийн мэргэжлийн эмч нарын баг ажиллаж авч амьсгалын замын халдвар тархахаас сэргийлж залуучуудын халууныг үзэж, асуумж авч эрэмбэлэн ангилалтыг хийж үзлэг шинжилгээнд хамруулан ажилласан ба үйл ажиллагаа дууссаны дараа үйл ажиллагаа явагдсан бүх анги танхимуудад мэргэжлийн ариутгагчаар халдваргүйжүүлэлтийг хийлгэлээ.

Сонгуулийн хэсгийн хороодод эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх тухай ЭМТ-ийн даргын 2020.10.12-ны өдрийн А/88 тоот тушаалыг гарган сонгууль зохион байгуулах үйл явцад коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сонгогчдын биеийн халууныг үзэх , гарын халдваргүйжүүлэх , тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор сонгуулийн 60 хэсгийн хороон дээр ЭМТ, ӨЭМТ –үүдээс нийт 120 эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг томилон ажиллуулж сонгогчдын халууныг үзэж зөвлөгөө өгч ажиллаа.

Сонгуулийн хэсгийн хороон дээр ажилласан дээрх эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд нэг удаагийн халад-120ш, амны хаалт-240ш малгай-120ш, гар халдваргүйжүүлэх уусмал-/30мл-/120ш, нэг удаагийн бээлий-600ш-тус тус олгосон. Мөн ЭМТ-ийн удирдлагын багийн 13 гишүүн сонгуулийн 60 хэсгийн хороодоор явж халдвар хамгааллын дэглэмийн байдалд хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаа.

Коронавируст халдварын илрүүлэг шинжилгээ хийх үйл ажиллагаа хийх болсонтой холбогдуулан шинжилгээний цэгүүд дээр ажиллах 81 эмч эмнэлгийн ажилтнуудад халдвар хамгааллын чиглэлээр болон хамгаалах хувцас хэрэгслийн өмсөж тайлах, хог хаягдлын менежментийн чиглэлээр 2020.11.9-13-ны хооронд сургалт дадлагыг хийлгэлээ.





Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Маскаа зүүцгээе, гараа угаая” 2 сарын аяныг зохион байгуулах тухай Улсын онцгүй комиссын 2020.10.19-ний өдрийн 04 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллах ажлын хүрээнд Гараа угаацгаая" "Маскаа зүүцгээе" аянд нэгдэн ЭМТ-ийн НЭМА, ХСХА Чанарын алба хамтран иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч 5 төрлийн гарын авлага материал 100ш амбулаториор үйлчлүүлэгчдэд тараалаа.





| | | |
|---|---|---|
| | | Коронавируст халдварын илрүүлэг шинжилгээ хийх үйл ажиллагаа хийх болсонтой холбогдуулан шинжилгээний цэгүүд дээр ажиллах 81 эмч эмнэлгийн ажилтнуудад халдвар хамгааллын чиглэлээр болон хамгаалах хувцас хэрэгслийн өмсөж тайлах, хог хаягдлын менежментийн чиглэлээр 2020.11.9-13-ны хооронд сургалт дадлагыг хийлгэлээ<br><br>2020.11.13-аас эхлэн дүүргийн хэмжээнд коронавируст халдварын илрүүлэг шинжилгээг 14 цэг дээр хийхээр зохион байгуулж одоогийн байдлаар нийт 17067 иргэнийг шинжилгээнд хамруулаад байна.<br><br>Дүүргийн хэмжээнд 11-р сард гарсан коронавируст халдварын батлагдсан 5 голомтын 18 тохиолдлын ойрын болон дам хавьтлын тандалт судалгааг хийж ажилласан ойрын хавьтлын нийт 175, дам хавьтлын 1152 хүнийг тусгаарлан хяналтанд авч хяналт тавин ажилласнаас 2020.12.07-ны байдлаар ойрын хавьтлын 4 гэртээ, 21 тусгаарлах байранд, , тус тус тусгаарлагдан хянагдаж байна. Дам хавьтлын 570 хүн гэрийн хяналтанд хянагдаж байна.<br><br>**Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг хангах, үнэлэлт дүгнэлт өгөх, түүний мөрөөр цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр** |

| № | ЭМТҮЧАБ-ын хурал | Хийсэн хугацаа | Хэлэлцсэн асуудлын тоо | Шийдвэрлэсэн асуудал |
|---|---|---|---|---|
| 1 ХУЭМТ | | | | |
| 1 | Хурал №1<br>Чанарын удирдлагын зохион байгуулалт | 1 сард | 2 | Шийдвэрлэсэн 8<br><br>Биелэлт 100% |
| | Хүний нөөцийн чадавхи | | | |
| 2 | Хурал №2<br>Эмгэг судлалын 2019 оны тайлангийн хурлын хэрэгжилт<br>Эмнэлзүйн стандартын хэрэгжилт | 1 сард | 4 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эрсдэлийг тодорхойлох, алдаа зөрчлийг мэдээлэх, тогтолцоо бий болгох | | | | |
| | | | Яаралтай тусламжийн бэлэн байдлыг ханган ажиллах | | | | |
| | | 3 | Хурал №3<br>Ураг нярай болон хүүхдийн эндэгдлийн асуудал, пренаталь эндэгдлийн байдал | 3 сард | 2 | | |
| | | | Хүүхдийн яаралтай тусламжийн бэлэн байдлыг ханган ажиллах | | | | |
| | | 4 | Яармаг салбарын чанарын багийн хурлын тоо 4 | 1.14, 3.26,5 .1, 6.11 | 4 | Биелэлт 100% | |
| | | 5 | Хэвтэн эмчлүүлэх тасгийн чанарын багийн хурлын тоо 4<br>“COVID-19 “ –ын бэлэн байдал<br>ХСХ –ын тушаал шийдвэр, зааврын хэрэгжилт<br>ЦЦБ-ний хэрэглээ | 2.6, 2.18, 3.11,4 .2 | 4 | Биелэлт 100% | |
| | | 6 | Төв салбарын чанарын багийн хурлын тоо 4<br>Жирэмсэний нэг цэгийн чиг үүргийн талаар эмч нарын ачаалал бууруулах<br>ДШБ эмчийн хяналт, хүндрэлгүй үйлчлүүлэгчийг өрхийн ЭМТ хянуулах | 1.14 5.5 | 2 | Биелэлт 100% | |
| | | 7 | Хурлын №4<br>Чанарын хагас жилийн ажлын тайлан<br>Эрсдэл аюулгүй байдлын үнэлгээ, авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө | 6.11 | 2 | Биелэлт 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | Хурал №6<br>ЭМТҮБАБА ХУЭМТ-ийн ЁЗХХ хамтарсан хурал<br>Ёс зүйн алдаа гаргасан эмч нарын асуудлыг хэлэлцсэн | 9.18 | 1 | Биелэлт 100% |
| 9 | Хурал №7<br>Сайн туршлага 2020 арга хэмжээнд оролцох тухай | 10.27 | 2 | Биелэлт 100% |
| ЭМТҮЧАБА нь 2020 онд 50 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 2020 оны 1 сарын 15-нд батлуулсан. 7 зорилтын хүрээнд хүрээнд төлөвлөсөн ажлууд хэрэгжсэн. ЭМТҮЧАБА-ын хурлыг 18 удаа хийж, 23 асуудлыг хэлэлцэж, 100% хэрэгжүүллээ. | | | | |

**Тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт:**

- ХУЭМТ-ийн 2019 оны 05 сарын 28-ны өдрөөс 2023 оны 3 сарын 28-ны өдрийг хүртэл 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх чанарын хөгжлийн хөтөлбөрийг 7 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.
- Эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээний биелэлтийг ханган ажиллаж 3,1 тэрбум төгрөгний санхүүжилт авсан. Хэвтэн эмчлүүлэх, өдрийн эмчилгээ, хөнгөвчлөх эмчилгээ, өдрийн хими, амбулаторийн үзлэг, оношилгоо шинжилгээ гэсэн 6 төрлийн тусламж үйлчилгээний зардлыг нөхөмжлөн авч байна
- 2020 онд ХУЭМТ-ийн хэмжээнд хэрэгжиж байгаа эмчилгээ оношилгооны стандарт, эмнэлзүйн удирдамжийн тоо: /давхардсан тоогоор/ 1.Хэвтэн эмчлүүлэх тасаг эмчилгээ оношилгооны стандарт 91, эмнэлзүйн удирдамж 32 2.Поликлиникийн тасаг эмчилгээ оношилгооны стандарт 256, эмнэлзүйн удирдамж 104 , Нийт 347 эмчилгээ оношилгооны стандарт, 135 эмнэлзүйн удирдамжийг мөрдөн ажиллаж, 304 анхан шатны маягтыг хөтлөн ажиллаж байна

  ЭМТҮЧАБА нь 2020 онд 50 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 2020 оны 1 сарын 15-нд батлуулсан. 7 зорилтын хүрээнд хүрээнд төлөвлөсөн ажлууд хэрэгжсэн. ЭМТҮЧАБА-ын хурлыг 18 удаа хийж, дараах асуудлаар Үүнд:

  Чанарын удирдлагын зохион байгуулалт

  Хүний нөөцийн чадавхи

| | | |
|---|---|---|
| | | Эмгэг судлалын 2019 оны тайлангийн хурлын хэрэгжилт<br>Эмнэлзүйн стандартын хэрэгжилт<br>Чанарын үзүүлэлт, үзүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөлт, биелэлт<br>Эрсдэлийг тодорхойлох, алдаа зөрчлийг мэдээлэх, тогтолцоо бий болгох, үр дүнг тооцох ,эргэн мэдээлэх<br>Яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангаж ажиллах<br>Ураг нярай болон хүүхдийн эндэгдлийн асуудал, пренаталь эндэгдлийн байдал, хүүхдийн яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангаж ажиллах<br>"COVID-19 " –ын бэлэн байдал, ХСХ –ын тушаал шийдвэр, зааврын хэрэгжилт<br>ЦЦБ-ний хэрэглээ, жирэмсний нэг цэгийн тусламж үйлчилгээ, аюулгүй байдал, тав тухтай орчинг бүрдүүлэх<br>Эмч нарын ачаалал тодорхойлох, хүний нөөцийн чадавх хангалт<br>ДШБ эмчийн хяналт, хүндрэлгүй үйлчлүүлэгчийг өрхийн ЭМТ хянуулах<br>Чанарын хагас жилийн ажлын тайлан<br>ЭМТҮБАБА ХУЭМТ-ийн ЁЗХХ хамтарсан хурал<br>Ёс зүйн алдаа гаргасан эмч нарын асуудлыг хэлэлцсэн<br>Сайн туршлага 2020 арга хэмжээнд оролцох тухай 23 асуудлыг хэлэлцэж, 100% шийдвэрлэн ажиллаа.<br>➢ COVID – 19 цар тахлын үед эмч эмнэлгийн мэргэжилтний сэтгэл зүйн дархлааг дэмжих зорилгоор "Сэтгэлийн илгээмж" хайрцаг аялуулж 300 гаруй талархлын захидлыг хүргэсэн, -"Хобби бүхэн сайхан" уралдаан, "төрсөн өдрийн мэндчилгээ, сэтгэлийн мэндчилгээ цахим илгээмж"-ийг нийт 114 эмч ажилтанд илгээсэн байна.<br>➢ Сэтгэл ханамжийн асуумж судалгаанд нийт 3359 үйлчлэгч хамрагдсан бөгөөд түүний 70,2%-ийг эмэгтэйчүүд, 29,8%-ийг эрэгтэйчүүд эзлэж байна. Үйлчлүүлэгчийн зэрэг сэтгэл ханамжийн хувь 91% байгаа нь өнгөрсөн оны мөн үеэсээ 0,6%-иар дээшилсэн байна<br><br>**Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд: 2020 онд**<br><br>• Амбулаториор нийт 256685 хүнд үзлэг хийснээс Амбулаторид өвчний учир –42,4%, урьдчилан сэргийлэх үзлэг – 46%, идэвхитэй хяналт- 11,3%, дуудлага- 0,07%-ийг эзэлж байна. |

- АД-илрүүлгийн УБ –ын дундаж 48,7 %, ЧШ-ийн илрүүлгийн УБ-ын дундаж 44%-тай байгаа бөгөөд ХУЭМТ –д АД- илрүүлэгт үзлэг хотын дунджаас 6,4% -иар их , ЧШ-ийн илрүүлэгт үзлэг хотын дунджаас 4,2%-иар их байна.
- Дүүргийн хэмжээнд жирэмсний хяналтанд хамрагдсан эхчүүдийн 89 хувь нь жирэмсний эрт үедээ буюу эхний 3 сартайдаа, 0,9 хувь нь 7 ба түүнээс дээш сартай хяналтанд хамрагдсан байна.
- Хэвтэн эмчлүүлэх тасагт нийт 3321 хүнийг хэвтүүлэн эмчилсэн ба нас баралт 9 тохиолдол гарч, 86% задланд орж, онош тохирсон. Үндсэн оношийн зөрөө гараагүй, хоног болоогүй нас баралт гараагүй.
- 0-1насны хүүхдийн эндэгдэл өмнөх оноос 4 тохиолдлоор буурч , хотын дунджаас доогуур , 1-5 насны хүүхдийн эндэгдэл 5 тохиолдол бүртгэгдэж, хотын дундажаас 0,1 промилоор их байна.
- Нийт халдварт өвчний 1014 тохиолдол гарч өмнөх оны мөн үеэс 890 тохиолдлоор буурч хотын дунджаас 31,6 промилоор доогуур байна.

**Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, өөрийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын үйл ажиллагааг үнэлнэ.**

| № | ХУЭМТ-ийн Чанарын үзүүлэлт | 2019 он | 2020 он |
|---|---|---|---|
| 1 | Нийт үйлчлүүлсэн иргэдийн тоо | 819322 | 692486 |
| 2 | АД эрт илрүүлэг | 56 | 164 |
| 3 | ЧШ 2 илрүүлэг | 5 | 12 |
| 4 | Хөхний өмөн илрүүлэг | 17 | 17 |
| 5 | Умайн хүзүүний эрт илрүүлэг | 24 | 40 |
| 6 | Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг | 3 | 4 |
| 7 | Гэрийн идэвхтэй эргэлтийн хувь | 31,2% | 34,9% |
| 8 | Жирэмсний эхний 3 сарын хяналт | 89,8% | 89% |
| 9 | Эхийн эндэгдлийн түвшин | 0 | 0 |
| 10 | Гэрийн төрөлт | 9 | 9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 11 | Нялхсын эндэгдлийн түвшин | 27 | 23 |
| | | 12 | 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин | 5 | 5 |
| | | 13 | Амьгүй төрөлтийн түвшин | 15 | 16 |
| | | 14 | Сүрьеэгийн өвчлөлийн түвшин | 175 | 200 |
| | | 15 | Цочмог халдварт өвчин | 1469 | 579 |
| | | 16 | Халдварт өвчин | 1904 | 1014 |
| | | 17 | Хоног болоогүй нас баралт | 0 | 0 |
| | | 18 | Оношийн зөрөө | 0 | 0 |
| | | 19 | Гэрт нас барсан | 340 | 318 |
| | | 20 | Гэрийн хяналтгүй нас баралт /насанд хүрэгсэд/ | 0 | 0 |
| | | Нийт үзүүлэлтийн 95,5% өмнөх оны үзүүлэлтээсээ ахиж сайжирсан. 0-1 насны хүүхдийн эндэгдэл 4 тохиолдлоор буурсан, оношийн зөрөө гараагүй, хоног болоогүй нас баралт гараагүй, халдварт өвчин 890 тохиолдлоор буурсан. | | | |

| | | № | Гүйцэтгэсэн ажлын нэр | Төрөл | гүйцэтгэл | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
